**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ 2021 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2022.01.24

| № | Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан нөхцөл тайлбар) |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Он | Түвшин | |
| **НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО** | | | | | | |
| **“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх** | | | | | | |
| 1.1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 1 | Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ. | | Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагад чиглэсэн мэдээлэл сурталчилгааны тоо-12<br><br>Хяналт шалгалтын тоо-12 | - | - | Мэргэжлийн хяналтын газраас 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 15 объектод төлөвлөгөөт шалгалтыг хийсэн. Шалгалтаар 50 зөрчил илрүүлж, газар дээр нь 10 зөрчлийг арилгуулав. 8 газарт 35 заалт бүхий албан шаардлага хүргүүлээд байна. Албан шаардлагын биелэлт тооцох хугацаа болоогүй байна.<br>Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл, Хүний аюулгүй байдлын академитай хамтран 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнуудыг чадавхжуулах “Эрсдэлийн удирдлага, эрсдэлийн үнэлгээний аргачлал” сэдэвт сургалт, 30-ны өдөр "Ажил олгогч /удирдах ажилтан/-ийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт"-ыг тус тус цахимаар зохион байгуулж, төрийн болон орон нутгийн 34 байгууллага, хувийн хэвшлийн 25 аж ахуйн нэгж буюу нийт 59 аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан 67 ажилтан, 59 аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч, удирдах албан тушаалтан 70 хүнийг хамруулснаас 48 нь шалгалтад тэнцэж, сертификат олгосон.<br>УУЖС Политехник коллежтой хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан бэлтгэх сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Тус сургалтад ААНБ хувиараа хөдөлмөр эрхлэгч 9 иргэн, 23 аж ахуйн нэгжийн 36 ажилтныг хамруулсан.<br>Эрүүл мэндийн газраас “Ковид-19” халдвар голомтлон гарсан буюу халдвар гарсан албан байгууллага, айл өрхийн 2224 объектын 180294 мкв талбайд ариутгал халваргүйтгэл хийгдсэн.<br>Аж ахуйн нэгж байгууллагын дотоод орчинд цэвэрлэгээ ариутгал хийх халдвараас сэргийлэх чиглэлээр 4 байгууллагын 70 ажилтан, албан хаагчид мэдээлэл сургалт сурталчилгаа хийж, зөвлөгөө өгсөн байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хувийн хэвшлийн 59 байгууллагад 14 удаагийн сургалтыг зохион байгуулсан.<br>Хувийн хэвшлийн 15 байгууллагад хяналт шалгалт хийсэн.<br>Халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж, зөвлөгөө мэдээлэл, өгсөн байгууллагын тоо - 4<br>Хамрагдсан иргэдийн тоо - 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Хэрэгжилт 100 хувь** |
| 2 | Төрийн болон Орон нутгийн өмчит байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлж ажиллана. | | Төрийн болон Орон нутгийн өмчит байгууллагад чиглэсэн мэдээлэл сурталчилгааны тоо-24<br><br>Хяналт шалгалтын тоо-12 | | | Мэргэжлийн хяналтын газраас 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төрийн 1, орон нутгийн өмчит 4 нийт 5 байгууллагад 2 хяналтын чиглэлээр төлөвлөгөөт шалгалтыг хийсэн. Шалгалтаар 15 зөрчил илэрч зөрчлийг арилгуулахаар 10 заалт бүхий 3 албан шаардлага хүргүүлээд байна. Биелэлт тооцох хугацаа болоогүй байна<br>Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын сайн туршлага солилцох замаар Монгол Улсын хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын менежментийн тогтолцоог сайжруулах зорилго бүхий бага хуралд аймгийн ХАБЭА-н салбар зөвлөлийн 11 гишүүн оролцож, “Аюулгүй байдал ба Ковид19”, “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо”, “Эрсдэлийн менежмент”, “Дижитал шилжилт ба аюулгүй байдал”, “Хөдөлмөрийн эрүүл мэнд”, “ХЭМАБ-ын сургалтын тогтолцоо” гэсэн багц 6 сэдвийн хүрээнд 27 илтгэлийг сонсож, мэдээлэл авсан.<br>УУЖС Политехник коллежтой хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан бэлтгэх сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, 8 төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын 8 албан хаагчийг хамруулсан.<br>Эрүүл мэндийн газраас 2021 оны жилийн эцсийн байдлаар 2224 объектын 180294 мкв талбайд ариутгал халваргүйтгэлийг хийж, байгууллагын дотоод орчинд цэвэрлэгээ ариутгал хийх халдвараас сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор 9 байгууллагын 160 гаруй албан хаагчдад сургалт сурталчилгаа хийж, зөвлөгөө өгсөн байна.<br>Салбарын хэмжээнд ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нөөц дунджаар 30 хоног байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Төрийн болон орон нутгийн өмчит 14 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн байна.<br>Хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн горимыг хангаж ажиллах талаар 5 төрлийн зөвлөмжийг өгч ажиллав.<br>16 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна.<br>Халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж, зөвлөгөө мэдээлэл, өгсөн байгууллагын тоо 9, хамрагдсан иргэдийн тоо 160<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 1.1.2. “Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдал, хариу арга хэмжээг хангах арга хэмжээг зохион байгуулж, санхүүжилтийг шийдвэрлэнэ. | | | | | | |
| 3 | “Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллана. | | Ковид-19-ын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийнэ.<br><br>Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-90 | 2019 | Ковид-19-ын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж эхэлсэн. | Аймгийн Шуурхай штабын Ковид-19-ын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөөг 80 арга хэмжээтэйгээр төлөвлөн, аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. Хэрэгжилтийн хувь 2021 оны жилийн эцсийн байдлаар 92 хувьтай хэрэгжсэн байна.<br>Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан эрсдэлийн үнэлгээг 12 удаа хийж, зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээний төлөвлөгөөнд 3 удаа тодотгол хийсэн. Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд:<br>1. Аймгийн хэмжээнд нийт ковидын эмчилгээний 266 ор бэлтгэн, иргэдэд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмчилгээ, үйлчилгээг хүргэж байна.<br>2. Эрүүл мэндийн байгууллагуудад 250 эмч, сувилагч бэлэн байдлыг ханган, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.<br>3. 2021 оны жилийн эцсийн байдлаар батлагдсан 5573, үүнээс хүүхэд 3836, нас баралт 18, эдгэсэн 5522, эмчилгээний тасагт эмчлүүлж байгаа 24 иргэн байна. Дархлаажуулалтын 1 дүгээр тунд 12690, 2 дугаар тунд 12054, 3 дугаар тунд 4597, ПГУ-ийн шинжилгээнд хамрагдсан 20309, түргэвчилсэн шинжилгээнд 36575 иргэн хамрагдсан. Ковидын эсрэг эмийн 25 хоногийн нөөцтэй байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Ковид-19-ын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөөнд 3 удаа тодотгол хийж, 80 арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.<br>Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-92<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 1.1.3. Мэргэжлийн байгууллагуудыг чадавхжуулах, албан хаагчдыг сургах, шаардлагатай тоног, төхөөрөмж, хамгаалалтын хэрэгслээр хангах арга хэмжээг зохион байгуулна. | | | | | | |
| 4 | Мэргэжлийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгслээр хангах арга хэмжээг зохион байгуулна. | 123.0 | Мананцар гаргагч, цахилгаан автомакс, богино долгионы утас, хамгаалах хувцсаар хангана.<br><br>Ариутгалын автомашин худалдан авна. | 2019 | Ариутгалын автомашины хөрөнгийг шийдвэрлэсэн. | Ковид-19 халдвараас сэргийлэх хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах зорилгоор аймгийн Онцгой комиссоос Нэгдсэн эмнэлэгт 3.6 сая төгрөгийн вакум хаалт, 2.8 сая төгрөгийн цахилгаан үүсгэгч мотор, 1.6 сая төгрөгийн пос машин, 2.5 сая төгрөгийн халдвартын тасгийн камержуулалт болон ойрын холбоо зэрэг шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэж, шаардлагатай тоног төхөөрөмж хэрэгслээр хангасан.<br>Мөн аймгийн Нэгдсэн эмнэлэг өөрийн нөөц 7.8 сая төгрөгийн хөрөнгөөр амбулаторийн тасгийн орох хэсэгт бүрэн автомат ариутгалын хаалгыг байршуулсан.<br>Мөн орон нутгийн 10.5 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгөөр өвчтөний ор, хөнжил гудас тус бүр 30 ширхэг, аймгийн Онцгой комиссоос нийт 95.4 сая төгрөгийн үнийн дүн бүхий 7035 ширхэг түргэвчилсэн оношлуураар хангаж ажилласан.<br><br>Орон нутгийн хөгжлийн сангийн 68.0 сая төгрөгийн хөрөнгөөр ариутгалын автомашин худалдан авч, Онцгой байдлын газарт хүлээлгэн өгсөн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Нийт 124.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан.<br>ОНХСангийн 68.0 сая төгрөгөөр автомашин худалдаж авсан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 5 | Мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдыг сургаж чадавхжуулна. | | Мэргэжлийн байгууллагын албан хаагчдыг сургаж дадлагажуулна. | | | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт дутагдалтай нэн шаардлагатай мэргэжлээр эмч, мэргэжилтнүүдийг богино хугацаанд сургаж чадавхжуулах зорилгоор цусны транспузиологич эмч, бага эмч, урологи, хавдрын хими эмчилгээ, компьютер томографын техникч, ДОХ/БЗДХ-ын эмч, хавсарсан гэмтэл судлал, яс үений гэмтэл судлал зэрэг 8 чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил олгох болон дээшлүүлэх сургалтад хамруулаа.<br>Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн ажилчдыг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургаж, дадлагажуулах чиглэлээр 21 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 391 ажилтан, албан хаагчдыг хамруулсан.<br>Орон нутагтаа Ковид-19 халдвар илрүүлэх шинжилгээ хийх чадавхыг бүрдүүлж, эмнэлгийн бактерилоги лабораторийн эмч, лаборант нар ПГУ-ын шинжилгээ хийх сургалтад хамрагдсан ба лабораторийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор орлон ажиллах Био-Анагаах судлаачдыг сургалтад хамруулж бэлтгэсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо – 400<br>Сургалтын тоо -28<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 1.1.4. Хүн амыг Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, сургууль, цэцэрлэгийн хүүхдийг томуугийн вакцинд хамруулна. | | | | | | |
| 6 | Эрсдэлт бүлгийн хүн амыг улирлын томуугийн вакцинд хамруулна. | 5.8 | Улирлын томуугийн вакцин 450 хүн тун | 2019 | 0-5 насны хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинаар дархлаажуулсан. | Эрсдэлт бүлгийн 2-11 насны хүүхдүүд болон жирэмсэн эхчүүдийг дархлаажуулах зорилгоор улирлын томуугийн 2250 хүн тун вакцин татан авч, 2021 оны жилийн эцсийн байдлаар 1468 хүн ам буюу 65.2 хувийг дархлаажуулалтад хамруулаад байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Эрсдэлт бүлгийн 1468 хүн амыг улирлын томуугийн вакцинд хамруулсан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 7 | Хүн амыг Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх вакцинд хамруулна. | | Насанд хүрэгчдийг Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх вакцинд хамруулна. | | | Улсын онцгой комиссын даргын 2021 оны 05 дугаар, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/33 дугаар тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж, Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын бэлтгэл ажлыг хангах 12 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө боловсруулан 100 хувь хэрэгжүүлсэн. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагааг аймгийн хэмжээнд түр 4, явуулын 5 нийт 9 цэгт зохион байгуулан ажиллаж байна.<br>ХӨСҮТ-өөс Синофарм үйлдвэрлэгчийн Вероцелл болон Пфайзер вакцин 31156 хүн тунг татан авч, 2021 оны жилийн эцсийн байдлаар 90.9 хувь буюу 29345 хүн тунг зарцуулаад байна.<br>18-аас дээш насны хүн амыг Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх вакцинд хамруулах ажил аймгийн хэмжээнд:<br>1-р тунгийн хамрагдалт 93.2 хувь,<br>2-р тунгийн хамрагдалт 94.2 хувьтай,<br>Нэмэлт тунгийн хамрагдалт 43.6 хувьтай явагдаж байна.<br>Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл бүртгэгдээгүй.<br>**Хүрсэн түвшин:**<br>1-р тунгийн хамрагдалт 93.2 хувь буюу улсын дүнгээс 0.1 пунктээр, аймгуудын түвшнээс 6.8 пунктээр өндөр.<br>2-р тунгийн хамрагдалт 94.2 хувь буюу улсын дүнгээс 2.8 пунктээр, аймгуудын түвшнээс 9.4 пунктээр өндөр.<br>3-р тунгийн хамрагдалт 43.6 хувь<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 1.1.5. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгаа сургалтыг зохион байгуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана. | | | | | | |
| 8 | Хариу арга хэмжээний бэлэн байдлын нөөцийг бүрдүүлнэ. | | Нөөцийн бэлэн байдлын үнэлгээ хийгдэж, нөөцийг сэлгэсэн байна. | | | Нөөцийн бэлэн байдалд 2021 онд 13 удаа үнэлгээ хийн, нөөц хангалтыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:<br>1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас орон нутагт шаардлагатай байсан 192 сая төгрөгийн өртөг бүхий PCR аппарат, 21 төрлийн багаж, тоног төхөөрөмжөөр хангасан.<br>2. Шаардлагатай ариутгалын бодис, хамгаалах хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгслийн зардал /арбидол эм, эмнэлгийн ор, гудас, хөнжил, хоолны халуун баригч сав, цахилгаан үүсгэгч мотор, вакум хаалт, пос төхөөрөмж, хүчилтөрөгчийн баллон, баллоны редуктор, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, цахилгаан зуух/ ПГУ шинжилгээний материал, түргэвчилсэн оношлуурыг 14-20 хоногийн нөөцтэй байхаар тооцоолж, сорьц зөөвөрлөх автомашины шатахууны зардал, явуулын шинжилгээний сорьц цуглуулах автомашины шатахууны зардал, эргүүл хяналт, шалгалтын постод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын хоол, шатахуун, шуурхай штабын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зардал, тусгаарлах байртай холбоотой зардлуудад нийт 310.5 сая төгрөгийн зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэн, нөөц хангалтыг нэмэгдүүлэн ажиллаж байна.<br>3. Эрүүл мэндийн яамнаас 486.2 сая төгрөгийн хамгаалах хувцас хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурыг татан авч, хариу арга хэмжээний нөөцийг бүрдүүлж ажилласан.<br>4. Орон нутгаас 95.4 сая төгрөгийн 7035 ширхэг түргэвчилсэн оношлуур, 21.3 сая төгрөгийн вирусийн эсрэг эм, 8.2 сая төгрөгийн баллон, редуктор 10 ширхэг, 16.0 сая төгрөгийн өтгөрүүлэгч 10 ширхэг, нийт 140.9 сая төгрөгийн хариу арга хэмжээний бэлэн байдлын нөөцийг бүрдүүлсэн.<br>5. Нөөцийн бэлэн байдлыг дахин нөхөн сэлгэсэн байдал: ЭМЯ-наас хуваарилсан вирусийн эсрэг 132.1 сая төгрөгийн 8 нэр төрлийн эм, 6.0 сая төгрөгийн 2 төрлийн хамгаалах хувцас хэрэгсэл, 8.2 сая төгрөгийн 4 төрлийн дархлаа сэргээх бэлдмэлээр хангагдаад байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Үндсэн эмчилгээний эмийн нөөц 7-10 хоног<br>Дусал шингэн болон шинж тэмдгийн эмчилгээний эмийн нөөц 20-45 хоног<br>Хамгаалах хувцас хэрэгслийн нөөц дунджаар 20 хоног<br>Зүү тариурын нөөц дунджаар 20 хоног<br>ПГУ шинжилгээний оношлуурын нөөц 9-10 хоног<br>Түргэвчилсэн оношлуурын нөөц 40 хоног<br>Голомтын халдавргүйжүүлэлт хийх нөөц 30 хоног<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 9 | Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулна. | | Шаардлагатай тохиолдолд гарын авлага тараах, цахим орчинд мэдээлэл бэлтгэж түгээнэ. | | | Коронавируст халдвар /Ковид-19/ -ын цар тахлаас сэргийлэх, дархлаа дэмжих, гэрийн нөхцөлд ариутгал халдваргүйжүүлэлт хийх заавар, зөвлөмж мэдээ, мэдээллийг эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудас болон аймгийн хэмжээнд олон нийтийн зар сурталчилгааны группээр түгээж ажилласнаар 4000 гаруй хандалтыг авсан байна.<br>Ковид-19 цар тахлаас сэргийлэх 18 төрлийн 3200 гаруй гарын авлага, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалт сурталчилгааны материалыг худалдаа, үйлчилгээний байгууллагуудаар тараан нийтэд хүргэж, мэдээлэл зөвлөгөө өгсөн.<br>Мөн вакцинд хамрагдсан 7000 гаруй иргэнд Ковид-19 халдварын эсрэг вакцины урвал, хүндрэл болон эсрэг заалт, дархлаажуулалтын дараа баримтлах зөвлөмж бэлтгэн түгээсэн.<br>ДЭМБ-ын санхүүжилтээр нийт 8 бүлгийн 1320 иргэнд “Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх”, “Вакцины нэмэлт тунгийн дархлаажуулалтын ач холбогдол”, “Ковидын дараах хүндрэлээс урьдчилан сэргийлэх, хувь хүний дархлааг дэмжих энгийн аргууд” чиглэлээр сургалт сурталчилгаа хийсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Цахим мэдээлэлд хандалт авсан иргэдийн тоо- 4000<br>Тараасан гарын авлага 18 төрлийн - 3200<br>Мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо -1320<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 1.1.6. Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, сургууль завсардалтын эрсдэлийг тооцоолж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 10 | Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, хичээл сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | | Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээг 2 удаа хийнэ.<br><br>Үнэлгээнд үндэслэн тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | | | Улсын онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 18 дугаар түр журам, БШУЯ-ны 2021 оны 02 дугаар сарын А/58 дугаар тушаалаар батлагдсан түр журмын дагуу танхимын болон танхимын бус хэлбэрээр хичээллэх үед гарах эрсдэлийг 02 дугаар сарын 24-26-ны өдөр, 05 дугаар сарын 5-7-ны өдрүүдэд СӨБ, ЕБС-иудад эрсдэлийн үнэлгээг хийж, сургууль, цэцэрлэгүүдэд зөвлөмжийг хүргүүлсний дагуу халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллаж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:<br>- Цар тахлаас сэргийлэх санамж, зөвлөмжийг өдөр бүр багш, сурагч, эцэг эхийн 82-92 хувьд хүргэж байна.<br>- БШУЯ, Жайка болон ДЗОУБ–ын 10.5 сая төгрөгийн санхүүжилтээр сургууль, цэцэрлэг бүрт 2 удаа халдваргүйтгэл хийсэн.<br>- Нийт багш, ажилчдын 65% нь бүрэн тунгийн вакцинд хамрагдсан. Өвчтэй болон жирэмсэн багш, 18 нас хүрээгүй сурагчид вакцинд хамрагдаагүй.<br>- 9 дүгээр сарын 1–ээс сумдын сургууль,11 дүгээр сарын 10-ны өдрөөс бүх сургууль БШУЯ-ны сайдын 491 дүгээр тушаалаар 5 өдрийн сургалтад хамрагдсан.<br>- Сургууль завсардах магадлалтай 6 хүүхдүүдийн судалгааг гаргаж, танхимын хичээлд суулгаж, эцэг эхэд нөлөөллийн ажил хийсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Эрсдэлийн үнэлгээ хийсэн тоо – 2<br>Үнэлгээнд үндэслэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо: 5<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **Нэг. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын зорилтын хүрээнд** | | | | | | **96.0 хувь** |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | |

<table>
<tr><td colspan="7">Эрүүл мэнд</td></tr>
<tr><td colspan="7">2.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.</td></tr>
<tr><td colspan="7">2.1.1. Эрүүл мэндийн салбарыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ.</td></tr>
<tr><td>11</td><td>"Эрүүл мэндийг дэмжих" арга хэмжээг хэрэгжүүлнэ.</td><td>50.0</td><td>Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь - 100</td><td>2019</td><td>"Эрүүл мэндийг дэмжих" арга хэмжээний хэрэгжилт хувь - 91.3</td><td>Арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2021 оны А/49 дүгээр захирамжаар батлуулж, 2 зорилт 7 арга хэмжээг 95.7 хувьтай хэрэгжүүлсэн.<br>Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний цогц тусламж үйлчилгээг үзүүлэх зорилтын хүрээнд :<br>Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, шинжилгээг зохион байгуулахад 24.4 сая төгрөгийг зарцуулсан. Үүнд:<br>- Эрсдэлт бүлгийн хүн амын дунд хавдрын урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг зохион байгуулж, 441 иргэнийг хамрууллаа.<br>- Хеликобактери илрүүлэх шинжилгээнд зорилтот насны 625 хүн хамрагдсанаас 377 хүний буюу 60.3 хувь нь эерэг гарсан үзүүлэлттэй;<br>- Тэмбүү өвчнийг илрүүлэх шинжилгээнд зорилтот бүлгийн 4500 хүнийг хамруулснаас 2 шинэ тохиолдлыг илрүүлж, эмчилгээнд бүрэн хамруулсан;<br>- Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд 1315 хүн хамрагдаж, 12 тохиолдол бүртгэгдэж хяналт, эмчилгээнд хамруулаад байна.<br>Халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх 18 удаагийн сургалт сурталчилгаа зохион байгуулж, “Эмчийн цаг” нэвтрүүлэг 4 удаа бэлтгэн цахим хуудсанд байршуулан, давхардсан тоогоор 6200 иргэдийн хандалттай.<br>Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:<br>- Лавлагаа шатлалын тусламж үйлчилгээний 10 мэргэжлээр эмч, мэргэжилтнийг урт болон богино хугацааны сургалтад хамруулж чадваржууллаа<br>- Мэс засал, Эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр зөвлөх эмч нарыг урьж орон нутагт богино хугацаагаар ажиллуулан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын байранд нь сургаж хөгжүүлсэн.<br>- Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нэн шаардлагатай, дутагдалтай мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ, мэс заслын чиглэлээр 2 эмчид урамшуулал олгон орон нутагт ажиллуулж байна.<br>- Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуульд суралцаж буй 2 оюутныг аймгийн Засаг даргын нэрэмжит оюутны тэтгэлэгт хөтөлбөрт хамруулсан.<br>- Ажлын байрны тасралтгүй сургалтаар давхардсан тоогоор 250 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан байна.<br>Хүрсэн түвшин:<br>Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь - 95.7</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Хэрэгжилт 95.7 хувь** |
| 2.1.2. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдийг орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангаж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 12 | Эрүүл мэндийн салбарын барилга байгууламжийг засварлаж, Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг эхлүүлнэ. | 16.0 | Халдвартын эмнэлгийн их засварын ажлын зураг төсөв хийлгэнэ.<br><br>Эмнэлгийн ажилчдын байрны засварын ажлын зураг төсвийг хийлгэнэ. | 2019 | 100 ортой аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгыг барьсан. | Аймгийн 2020 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын 8.0 сая төгрөгөөр Хүүхдийн эмнэлгийн барилгыг орон сууцны зориулалтаар засварлах ажлын зураг төсвийг Эрхэс констракшн ХХК гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн.<br>Мөн Халдвартын эмнэлгийн барилгын их засварын ажлын зураг төсөв боловсруулах ажлыг ММ архитектур ХХК гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Халдвартын эмнэлгийн их засварын зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэл – 100 хувь<br>Эмнэлгийн ажилчдын байрны засварын зураг, төсөв боловсруулах ажлын гүйцэтгэл – 100 хувь<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 13 | Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | 2,200.0<br><br>20.0 | Шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангана. | 2019 | Нийт 190.9 сая төгрөгөөр 22 төрлийн багаж, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл худалдан авч нийлүүлсэн. | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хөрөнгө оруулалтаар “Энхтусдэм” өрхийн эрүүл мэндийн төвд 53 нэр төрлийн 49.7 сая төгрөгийн, Баянтал сумын эрүүл мэндийн төвд 27 нэр төрлийн 6.2 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, эд хогшил нийлүүлэгдэж, анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологи нэвтрүүлсэн.<br>Монгол Улсын Засгийн газраас баталсан “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд байгуулах шүдний анхны кабинетыг Шивээговь сумын эрүүл мэндийн төвд нээж 54.0 сая төгрөгийн шүдний кабинетын тоног төхөөрөмжөөр хангагдан үйл ажиллагаа явуулж байна.<br>Эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулах техник тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах хангалтууд хийгдсэн.<br>Үүнд: ЭМЯ-ны санхүүжилтээр хүчилтөрөгчийн баллон 7 ширхэг, редуктор 5 ширхэг, дэлгэцтэй видео ларингаскоп, амбу, зайнаас халуун хэмжигч, дусал тогтоогч, зөөврийн зохиомол амьсгалын аппарат, кесар хагалгааны иж бүрдэл, зөөврийн рентген аппарат, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Genexpert аппаратын дагалдах хэрэгсэл вортекс аппарат, центрифуг, туб сав 400 ширхэг, цахилгаан автомакс 3 ширхэг, Ковидын үеийн бэлэн байдлыг хангах ор, хөнжил гудасны иж бүрдэл 30 ширхэг зэрэг шаардлагатай багаж хэрэгслээр хангаад байна.<br>Эрүүл мэндийн яамнаас орон нутгийн лабораторийн хүчин чадлыг сайжруулж, 192 сая төгрөгийн ПГУ/PCR шинжилгээний тоног төхөөрөмж, 31 сая төгрөгийн оношлуураар хангаж, шинжилгээ хийгдэж эхлээд байна.<br>Мөн Унгар улсын элчин сайд Борбала Обрушанский аймгийн Нэгдсэн эмнэлэгт 148.0 сая төгрөгийн амьсгалын аппарат хандивласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Тоног төхөөрөмж, эд хөрөнгийн тоо - 42<br>Төсөвт өртөг – 501.6 сая төгрөг<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 14 | Орчин үеийн оношилгоо, | | Хорт хавдрын хими, | 2019 | Хэвлийн | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хавдрын эмчийг хорт хавдрын хими |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлж, эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээг үзүүлнэ. | | уламжлалт эмчилгээг хийж эхэлнэ. | | хөндийн дурангийн мэс засал хийж эхлүүлсэн. | эмчилгээний мэргэшүүлэх сургалтад хамруулан чадавхжуулсан бөгөөд орон нутаг дахь хорт хавдартай өвчтөнийг 100 хувь хяналтад авч, эмийн курс эмчилгээ хийж эхэлсэн.<br>Хавдар судлалын үндэсний төвийн резидент мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний эмч Ж.Алтаншагайтай гэрээ байгуулан, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ, хавдрын сэхээн амьдруулах болон химийн уламжлалт эмчилгээг орон нутагт хийх боломжийг бүрдүүлээд байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Орон нутагт хавдартай өвчтөнийг 100 хувь хяналтад авсан.<br>Хорт хавдрын хими эмчилгээний эмч бэлтгэгдсэн.<br>Эмийн эмчилгээ хийж байна.<br>Химийн эмчилгээ хийх орчин нөхцөлийг бүрдүүлж байна.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 15 | Яаралтай тусламж үйлчилгээний хүртээмж чадавхыг сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ. | 24.0 | Эрүүл мэндийн төвийг яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр хангана. | 2019 | Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Өрх, Баянтал сумын эрүүл мэндийн төв автомашинтай болсон. | 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Шивээговь сумын эрүүл мэндийн төвийг яаралтай тусламж, үйлчилгээний автомашинаар хангасан.<br>Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад 700 сая төгрөгийн амьсгалын аппратыг УИХ-ын гишүүн Сү.Батболд гишүүний дэмжлэгтэйгээр авсан<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 16 | Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоог зохион байгуулна. | | Хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь 50.0<br><br>Сүрьеэ өвчлөлийн түвшин - 13.8<br><br>Тэмбүү өвчний түвшин - 24.2 | 2019 | Хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь - 59.7<br><br>Сүрьеэ өвчлөлийн түвшин - 14.0<br><br>Тэмбүү өвчний түвшин - 24.6 | Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг шинжилгээг зохион байгуулах тухай аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/18 дугаар тушаалын дагуу зохион байгуулж, эрт илрүүлэг, үзлэг дунджаар 80.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:<br>- Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт 18-с дээш насны 11001 иргэн хамрагдахаас 10362 иргэн хамрагдаж, 94.2 хувьтай;<br>- Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 40-с дээш насны 4974 иргэн хамрагдахаас 4820 иргэн хамрагдаж, 96.9 хувьтай;<br>- Хөхний хорт хавдрын эрт илүүлэг үзлэг шинжилгээнд 20-с дээш насны 5235 иргэн хамрагдахаас 5126 иргэн хамрагдаж, 97.9 хувьтай;<br>- Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 1240 иргэн хамрагдахаас 181 иргэн хамрагдаж, 14.6 хувьтай;<br>- Элэгний хорт хавдар эрт илрүүлэх үзлэг 2017 оноос хойш 11746 иргэн хамрагдахаас 11440 иргэн хамрагдаж, 97.3 хувь<br>- Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 15 байгууллагын 578 ажилтан, 278 иргэн, ахмад настан урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.<br>- Хавдрын эрт илрүүлэг үзлэгийг эрсдэлт бүлгийн хүн амын дунд зохион байгуулснаар 441 хүнд үзлэг оношилгоо хийж, хортой хавдар 1, дахисан хорт хавдар 1, хортой байх магадлалтай 13, хоргүй хавдар 21, хавдрын урьтал өвчин 3 илэрсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоо, Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн хавьтлын илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, 1315 хүнийг хамрууллаа. Сүрьеэ өвчний 12 шинэ тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 6.7 байгаа нь улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байна.<br>- Тэмбүү өвчний илрүүлэг шинжилгээнд 5437 хүнийг хамруулсны 4500 хүн ам нь үзлэгт хамруулахаар төлөвлөсөн эрсдэлт бүлгийн иргэд байна. Тэмбүү өвчний 2 шинэ тохиолдол бүртгэгдэн эмчилгээнд бүрэн хамрагдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь 80.2<br>Сүрьеэ өвчлөлийн түвшин 6.7<br>Тэмбүү өвчний түвшин 1.1<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.1.4. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг нэвтрүүлж, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 17 | Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг нэвтрүүлнэ. | | Сүмбэр, Баянтал сумдын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээнд Мобайл технологи нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангана. | 2019 | Шивээговь сумын Эрүүл мэндийн төвд Мобайл технологи нэвтэрсэн. | Эрүүл мэндийн яамнаас ДЭМБ-ын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Говьсүмбэр аймгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чадавхыг сайжруулах нь” төслийн хүрээнд аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад үнэлгээ хийгдэж, Сүмбэр, Баянтал сумдын Эрүүл мэндийн төвүүдэд Мобайл технологийг нэвтрүүлэн, нийт 68.2 сая төгрөг бүхий 27 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангасан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Мобайл технологи нэвтэрсэн эрүүл мэндийн төвийн тоо-3<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 18 | Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангаж хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | Эмийн чанар аюулгүй байдлын программ хангамжийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.<br><br>Нэгдсэн эмнэлэгт эм зүйн албыг байгуулна. | 2019 | Бүх шатлалын эмч нар цахим жор бичих үйлчилгээ нэвтэрсэн. | Аймгийн хэмжээнд бүх шатлалын Эрүүл мэндийн байгууллагуудад цахим жор бичих эрх бүхий 33 эмч (Нэгдсэн эмнэлэгт 24, Шивээговь сумын эрүүл мэндийн төвд 2, Баянтал сумын эрүүл мэндийн төвд-1, “Энхтусдэм” Өрхийн эрүүл мэндийн төвд 6) ажиллаж байна.<br>2021 онд 7 эмийн санд давхардсан тоогоор 12304 иргэн цахим жороор үйлчлүүлсэн.<br>Аймгийн Нэгдсэн эмнэлэгт эм зүйн албыг зохион байгуулах ажлыг эхлүүлж, стандарт шаардлага хангасан өрөөг бэлтгэн, хүний нөөцийг бүрдүүлэх ажлыг хийж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Эм зүйн албыг байгуулах ажлыг эхлүүлсэн.<br>Эмийн чанар, аюулгүй байдлын программ хангамж бүрэн нэвтэрсэн.<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| 2.1.5. Жирэмсний хяналтыг сайжруулах замаар эхийн хүндрэлийг бууруулж, сэргийлж болох нялхсын эндэгдлийг багасгана. | | | | | | |
| 19 | Жирэмсний эрт үеийн хяналтын хамрагдалтыг нэмэгдүүлж, хүүхдийн эндэгдлийг бууруулна. | 5.0 | Жирэмсний эрт үеийн хяналтын эзлэх хувь - 87.7 | 2019 | Жирэмсний эрт үеийн хяналтын | Аймгийн хэмжээнд 2021 онд 472 эх төрж, 478 хүүхэд мэндэлсэн. Нийт 337 эмэгтэй жирэмсэн эхийг хяналтад авснаас эхний 3 сартай хяналтад 312 жирэмсэн эх хамрагдаж, эрт үеийн хяналт 92.5 хувьтай байна.<br>2021 онд нялхсын эндэгдэл 1 буюу 1000 амьд төрөлтөд 2.1 промиль |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Нялхсын эндэгдлийн түвшин - 7.0<br><br>5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин - 11.3 | | эзлэх хувь – 85<br><br>Нялхсын эндэгдлийн түвшин - 11.7<br><br>5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин - 11.6 | байна. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл бүртгэгдээгүй.<br>**Хүрсэн түвшин:**<br>Жирэмсний эрт үеийн хяналтын эзлэх хувь – 92.5<br>Нялхсын эндэгдэлийн түвшин -2.1<br>1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин – 0<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.1.6. Хүний нөөцийн хөгжлийг хангаж, нийгмийн хамгааллыг дэмжинэ. | | | | | | |
| 20 | Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийг дэмжин хөгжүүлнэ. | | Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь<br><br>Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тасралтгүй сургаж, чадавхжуулна<br><br>Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулна<br><br>Ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулна. | 2019 | Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн тухайн жилийн үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь- 94.1 | Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгаа хөтөлбөрийн хүрээнд 4 зорилт, 26 арга хэмжээ төлөвлөж, 90 хувьтай хэрэгжсэн байна. Үүнд:<br>- Нэн шаардлагатай мэргэжлээр мэргэшил олгох сургалтад 10 эмч, мэргэжилтнийг төрийн зардлаар суралцуулж байна.<br>- Байгууллагын дотоод сургалтаар “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ээр эрүүл мэндийн газрын 16 албан хаагчийг чадавхжуулсан.<br>- Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын ёс зүй харилцаа хандлага, үйлчилгээний чанарын талаар 400 гаруй иргэнээс санал асуулга авч, “Сэтгэл ханамж”-ийн судалгаа хийж, үр дүнд суурилсан арга хэмжээ авч ажиллах дүгнэлт зөвлөмж хүргүүлсэн.<br>- Орон нутагт ажиллахаар ирж байгаа эмч мэргэжилтнийг орон байраар хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор Нэгдсэн эмнэлгийн хуучин барилгыг ажилчдын байрны зориулалтаар засварлах зураг төсвийг гүйцэтгүүлж хүлээн авсан.<br>- Тайлант онд 3 их эмчийг орон сууцаар, 10 эмчийг тусгай өрөө бэлтгэн байрлуулан ажиллах нөхцөлөөр ханган ажиллуулж байна.<br>- Эрүүл мэндийн байгууллага бүр эрүүл мэндийн ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан нэгдсэн загвар бүхий ажлын хамгаалах хувцас, ажлын хэрэгслээр, Эрүүл мэндийн газрын албан хаагчдыг 2 төрлийн 1.9 сая төгрөгийн ажлын хувцсаар тус тус хангаж, Нэгдсэн эмнэлэг 9.4 сая төгрөгийн ажлын хувцасны захиалгыг өгөөд байна.<br>- Эрүүл мэндийн байгууллага бүр ажилтны дархлааг дэмжих зорилгоор улирал тутамд витамин, нэг удаагийн маск, гар ариутгагч, малгай, бээлийгээр ханган ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтны too -30<br>Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтны too -10 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийгмийн баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээний тоо - 3<br>Байр орон сууц, байраар хангагдсан эмч, эмнэлгийн ажилтны тоо -13<br>Зарцуулсан төсөв - 20.0 сая төгрөг<br>Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь - 90.0<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| **Зорилтын дундаж үнэлгээ** | | | | | | **95.6** |
| **Биеийн тамир, спорт** | | | | | | |
| **2.2. Нийтийн биеийн тамир, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлж, тамирчдын өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 2.2.1. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 21 | Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 40.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 | 2019 | Хөтөлбөрийн хэрэгжилт хувь - 97 | “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээ”–ний хүрээнд 3 зорилт, 6 арга хэмжээг батлуулан, 98 хувьтай хэрэгжүүлэн ажиллалаа.<br>Улсын аварга шалгаруулах тэмцээнд хөнгөн атлетик, усанд сэлэлт, жүдо, пауэрлифтинг, хөл бөмбөг, фут зал, сурын харваа, үндэсний бөх зэрэг төрлөөр оролцож 3 алт, 41 мөнгө, 44 хүрэл медаль хүртсэн.<br>Хорио цээрийн дэглэмийн үед чийрэгжүүлэх, дархлаа дэмжих зорилгоор ажлын байрны орчинд “Үлгэрлэлийг өөрөөсөө”, “30 минут X 365” биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж, 15 байгууллага биеийн тамирын хамтлаг байгуулж, 17 байгууллагын 437 албан хаагчийг хамруулсан.<br>“Чойр кросс vs Корона” гүйлт, “Эрүүл мэндийн түншлэл“ биеийн тамирын арга хэмжээ, “Коронаг- Короссоор- Халдварыг хөдөлгөөнөөр дарая” сэдэвт өглөөний гүйлт, аймгийн “Иргэдийн спортын наадам”-ыг спортын 14 төрлөөр тус тус зохион байгуулж, нийт 3432 иргэнийг хамруулсан байна.<br><br>Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Эрүүл мэндийн цахим гүйлт-2021“ биеийн тамирын арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 590 гүйгч нийт 7236 км зай туулж, нийлбэр 6.29 оноогоор Зүүн бүсийн аймгуудаа тэргүүлсэн. Мөн “Цахим гимнастрада” арга хэмжээг орон нутагт зохион байгуулж, 7 төрөл 12 ангилалд 27 баг улсын нэгдсэн уралдаанд шалгаран оролцсон. Орон даяар явагдсан алхалт, дугуй унaлтын сарын аяны хүрээнд “Машинаар биш дугуйгаар” хөдөлгөөн өрнүүлэн дугуйн аялал, буухиа уралдаан, 400 ба 800 м-ийн хамгийн хурдан жийгч, тогтмол дугуйгаар хичээллэгчдийг сурталчлах ТВ контент, дугуй засвар үйлчилгээ зэрэг төрөл ангиллаар 3 сар үргэлжилсэн арга хэмжээ зохион байгуулж 245 иргэн хамрагдсан.<br><br>Шивээговь, Баянтал, Сүмбэр сумдад биеийн тамирын арга хэмжээг тэгш хүртээмжтэй зохион байгуулах зорилгоор арга зүйн сургалтыг зохион байгуулж, “Санамж бичиг” байгуулан, сум тус бүрт 1 сая төгрөгийн үнэ бүхий 14 нэр төрлийн хэрэглэл олгосон.<br>**Хүрсэн түвшин**:<br>Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-98<br>**Хэрэгжилт 98 хувь** |
| 2.2.4. Шивээговь суманд Соёлын төв, Баянтал суманд соёл спортын цогцолборын барилга барина. | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 22 | Шивээговь суманд Соёлын төв, Баянтал суманд соёл спортын цогцолборыг барина. | 35.0 | Баянтал сумын Соёл, спортын цогцолборын зураг төсөв хийнэ. | 2019 | Шивээговь сумын Соёлын төвийн барилгын зураг төсөв хийгдсэн. | Баянтал сумын соёл, спортын цогцолборын зураг төсвийн ажлыг “Ориент плюс“ ХХК-аар 90 хувьтай гүйцэтгүүлж байна.<br>**Хүрсэн түвшин:** Зураг төсвийн ажлын гүйцэтгэл, хувь-90<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| **Зорилтын дундаж үнэлгээ** | | | | | | **94.0** |
| **Боловсрол** | | | | | | |
| **2.3. Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар хүртээмжийг сайжруулна.** | | | | | | |
| 2.3.1. Боловсролыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 23 | Боловсролыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 25.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 | 2019 | Хөтөлбөрийн хэрэгжилт хувь - 70 | Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/49 дугаар захирамжаар “Боловсролыг дэмжих арга хэмжээ”-г 10 арга хэмжээтэйгээр төлөвлөн, 75 хувьтайгаар хэрэгжүүлсэн байна.<br>- Элсэлтийн нэгдсэн шалгалтад бэлтгэх ажлын хүрээнд сорилго шалгалтыг 3 удаа зохион байгуулж, зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилласнаар “Элсэлтийн нэгдсэн шалгалт”-ын 8 хичээлийн хэмжээст оноо нэмэгдэж, Биологи, Газарзүй, Түүх, Нийгмийн ухааны хичээлүүдийн оноогоор улсад эхний 1-5 дугаар байр эзэлсэн амжилт үзүүлсэн.<br>- Орон нутагт дутагдалтай багшийн ажлын байранд ирж ажиллаж буй багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор 6 багшийн байрны түрээсийн төлбөрийг шийдвэрлэлээ.<br>- Аймгийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн чанарын үнэлгээний шалгалт”-ыг математик, монгол хэлний хичээлээр 4, 5, 6, 8, 9 дүгээр ангийн 1915 сурагчдыг хамруулан зохион байгуулж, чанарыг дундаж үнэлгээ 40 хувьтайгаар дүгнэгдсэн.<br>- Орчин цагийн боловсрол үүсч хөгжсөний 100 жилийн ой, Дэлхийн болон Монголын багш нарын баярын өдрийг угтан “Говьсүмбэр телевиз”-тэй хамтран “Боловсрол-100” цахим контент бэлтгэн, иргэд, олон нийтэд түгээсэн.<br>- “Цахим даалгаврын сан бүрдүүлэх” зорилгоор цахим программ худалдан авах гэрээг “Боловсролын хөгжлийн үнэлгээний төв”-тэй байгуулж, 6000 цахим даалгаврын сан бүрдүүлэн ажиллалаа.<br>- Монгол Улсын гавьяат багш Ш.Түмэн-Өлзийн нэрэмжит 18 дахь удаагийн Монгол бичгийн цахим уралдааныг зохион байгуулж, 120 багш, сурагчид оролцон, 86 цахим хичээлийн сантай болсон. Эх хэлний өдрийг тохиолдуулан “Сайхан бичигтэн” цахим уралдаанд нийт 165 иргэд, албан хаагч, сурагчид үндэсний монгол бичгээр зөв, сайхан бичиж оролцсон.<br>**Хүрсэн түвшин:**<br>Арга хэмжээний хэрэгжилт 95 хувь<br>Зарцуулсан төсөв-21.2 сая төгрөг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Хэрэгжилт 95 хувь** |
| 2.3.2. Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулна. | | | | | | |
| 24 | Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулна. | 1,750.0 | Сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл 75 хувь | 2019 | Сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл 20 хувь | Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн сургуулийн барилга нь 2020-2022 онд дамжин улсын төсвийн 3.3 тэрбум төгрөгөөр хийгдэхээр төлөвлөгдсөн бөгөөд 2020 онд 50.0 сая төгрөгөөр гадна бохир усны шугамын ажлыг гүйцэтгэсэн.<br>2021 онд барилга угсралтын ажлыг 06 дугаар сарын 10-ны өдрөөс бэлтгэл ажлыг хангаж, суурин бетоны узель, холбогч кран барилгын талбайд угсарч, суурийн ажлын бараа материалын татан, суурь суулгах газар шорооны ажил хийгдсэн байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Ажлын гүйцэтгэлийн явц- 25 хувь.<br>**Хэрэгжилт 18.2 хувь** |
| 2.3.3. Сүмбэр сумын 5 болон 1 дүгээр сургуулийн барилгыг 320 хүүхдийн барилгаар өргөтгөнө. | | | | | | |
| **25** | Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн 320 хүүхдийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулна. | 35.0 | Зураг төсвийг хийлгэнэ. | 2019 | - | Сүмбэр сумын 1-р сургуулийн 320 хүүхдийн сургуулийн барилгын зураг төслийг Орон нутгийн хөрөнгө оруулалтын 32.9 сая төгрөгөөр “Жаргалант хийц” ХХК гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Ажлын гүйцэтгэлийн явц- 100 хувь.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.3.4. “Чадварлаг багш” арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангана. | | | | | | |
| 25 | “Чадварлаг багш” арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгоно. | 20.0 | "Чадварлаг багш арга хэмжээ"-г хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах.<br><br>Урамшуулах багшийн тоо – 20<br><br>Дэмжлэг үзүүлэх багшийн тоо – 4<br><br>Боловсролын чанарын үнэлгээ -38 хувь<br><br>Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо 510 | 2019 | Урамшуулсан багшийн тоо -25<br><br>Багшийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтад 123 багшийг хамруулсан.<br><br>Боловсролын чанарын үнэлгээ - 35 хувь | “Багшийн хөгжлийн институт”-ээс зохион байгуулсан “Чадварлаг багш“ арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын танилцуулга сургалтад сургууль, цэцэрлэгийн удирдах 30 ажилтан хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлсэн.<br><br>Орон нутгийн багш нарыг ажлын гүйцэтгэлд нь суурилан урамшуулах зорилгоор “Чадварлаг багш” урамшууллын журмыг аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/282 дугаар захирамжаар батлан хэрэгжүүлж, журмын хүрээнд “Элсэлтийн нэгдсэн шалгалт” болон сурагчдын сурлагын ахиц, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, шилдэг хөтөлбөр арга зүйгээр үр дүн, амжилт гарган ажилласан 74 багшийг 18.6 сая төгрөгөөр урамшуулсан.<br><br>Орон нутагт дутагдалтай мэргэжлээр ажиллаж байгаа 6 багшийн байрны түрээсийг шийдвэрлэн тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлөөр хангасан.<br><br>Аймгийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн чанарын үнэлгээний шалгалт”-ыг 11 дүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд 4 дүгээр ангийн Монгол хэл, 5 дугаар ангийн Математик, 6 дугаар ангийн Математик, 8 дугаар ангийн Математик, 9 дүгээр ангийн Математик, Монгол хэлний хичээлүүдийг сонгон, нийт 5 сургуулийн 1915 сурагчийг хамруулан авахад дундаж үнэлгээ 40 хувьтайгаар дүгнэгдсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо 508.2 | Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх ажлын төлөвлөгөө боловсруулж, үнэлгээний 10 шинжээч багштай 5.0 сая төгрөгийн гэрээ байгуулан, 3 удаагийн сорилго шалгалт авч, зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилласны үр дүнд элсэлтийн ерөнхий шалгалтын аймгийн дундаж 520 оноонд хүрсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>"Чадварлаг багш арга хэмжээ"-г хэрэгжүүлэх бэлтгэл хангагдсан.<br>Урамшуулсан багшийн тоо-74 /18.6 сая төгрөг/<br>Дэмжлэг үзүүлсэн багшийн тоо-6<br>Боловсролын чанарын үнэлгээ-40<br>Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо-520<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 26 | Цахим зайн сургалтын платформыг хөгжүүлэн, багш нарын оролцоог дэмжиж, цаг хугацаа орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлнэ. | | Цахим хэлбэрээр мэргэжлийн болон ур чадвар, ёс зүйн сургалтад хамрагдсан багшийн тоо-150 | 2019 | Цахим сургалтад хамрагдсан багшийн тоо -2 | Багшийн Цахим Кампуст /esurgalt.itpd.mn/ цахим зайн сургалтад 62 багш, сонголтод сургалтад 70 багш мэргэжил арга зүйн чадвараа дээшлүүлсэн.<br>“Багшийн мэргэжил дээшлүүлэх институт”-ээс зохион байгуулсан сургалтын арга зүйгээ дээшлүүлэх төлбөртэй 5 төрлийн цахим сургалтад 115 багш, нээлттэй сургалтад 136 багш хамрагдаж мэдлэг чадвараа ахиулсан.<br>Монгол Улсын Засгийн газар, Удирдлагын академиас зохион байгуулсан “Төрийн албаны ёс зүй" сургалтад боловсролын салбарын 26 удирдлага, БШУЯ болон “Гүрэн академи”-ийн Дэлхийн хэмжээний менежер бэлтгэх сургалтад 24 удирдах ажилтан хамрагдсанаар давхардсан тоогоор нийт 433 багш цахим хэлбэрээр сургалтад хамрагдаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн.<br>Удирдлагын академийн мэргэжлийн багш нартай хамтран “Багшийн ёс зүй” харилцаа, хандлагын сургалтыг 5 дугаар сарын 24, 25-ны өдөр цахимаар зохион байгуулсан бөгөөд 220 багш хамрагдсан.<br>Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, МУБИС, МУИС-ийн багш нартай хамтран хими, биологи, физикийн хичээлийн багш, сурагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор сургалтуудыг цахимаар зохион байгуулж, 20 багш 185 сурагчийг хамруулсан..<br><br>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 52 багш нарт “Боловсролын тухай” хууль, “Багшийн ёс зүйн дүрэм” журмыг танилцуулж, зөвлөмжөөр хангах, харилцаа хандлага, сэтгэл зүйн асуудлаар арга зүйн зөвлөгөө, сургалтыг цахим, танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. Сургалтаар багш нарын баримтлах эрх зүйн баримт бичиг, ёс зүйн дүрмийн хэрэгжилт, сургууль, цэцэрлэгийн “Ёс зүйн орон тооны бус зөвлөл”-ийн үйл ажиллагаа, кейст үндэслэсэн зөвлөмж, багшийн ёс зүй харилцаа хандлагын талаар 2 удаагийн судалгааны үнэлгээ, анхаарах асуудал, боловсролын сэтгэлзүй, багшийн ёс зүй зэрэг асуудлаар Боловсрол, соёл урлагийн газрын дарга, мэргэжилтнүүд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн, Focus on the famile сургалтын төвийн сургагч багш Рэгжидмаа нар сургалтыг удирдлаа.<br>**Хүрсэн түвшин:** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сургалтад хамрагдсан багшийн тоо- 1108 /давхардсан тоогоор / **Хэрэгжилт 100 хувь** |
| 2.3.5. Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг сургууль, цэцэрлэгт сурах, хөгжихөд дэмжиж, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулна. | | | | | | |
| 27 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилгуудыг өргөтгөж, шинээр барина. | 1,500.0 | Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн барилгын ажлын явц 100 хувь | 2019 | Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн барилгын ажлын явц 85 хувь | Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн барилгын ажлыг улсын төсвийн 5.6 тэрбум төгрөгөөр Идэрчандмань ХХК 2019-2021 онд гүйцэтгэж байгаа бөгөөд энэ онд ашиглалтад хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн болович Коронавирусt халдвар (Ковид-19)-ын цар тахал нэмэгдэж, хил дээр гадна шугам сүлжээ, зуухны өргөтгөлийн бараа материал саатсантай холбогдуулан дулааны улиралд гадна шугам сүлжээ болон зуухны өргөтгөлийн ажлыг дуусгаж чадаагүйн улмаас хүлээлгэн өгөх боломжгүй болсон. **Хүрсэн түвшин:** Ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна. **Хэрэгжилт 90 хувь** |
| 28 | Сургууль, цэцэрлэг, дотуур байрны их засварын ажлыг үе шаттайгаар хийнэ. | 23.0 | Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн дотуур байрны засварын зураг төсөв хийлгэнэ.<br><br>Сүмбэр сумын 1-р сургуулийн гадна фасад, спорт заалны их засварын зураг төсөв хийлгэнэ. | 2019 | | Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн дотуур байрны их засварын ажлын зураг төсөв боловсруулах ажлыг Орон нутгийн хөгжлийн сангийн 14.2 сая төгрөгөөр “ММ архитектур” ХХК гүйцэтгэж байна. Барилга хөгжлийн төвд экспертизээр хянуулах шатандаа байна.<br><br>Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн гадна фасад, спорт заалны их засварын зураг төсөв боловсруулах ажлыг Баяр Мега Сервис ХХК Орон нутгийн хөрөнгө оруулалтын 8 сая төгрөгөөр гүйцэтгүүлж, хүлээн авсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн дотуур байрны засварын зураг төсвийн ажлын гүйцэтгэл-95 хувь<br>Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн гадна фасад, спорт заалны их засварын зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэл 100 хувь<br>**Хэрэгжилт 97.5 хувь** |
| 2.3.6. Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж буй болон төгсөөд орон нутагтаа ажиллах оюутнуудад сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно. | | | | | | |
| 29 | Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудын судалгааг гаргаж, сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно. | 20.0 | Тэтгэлэг олгох оюутны тоо-10 хүртэл | 2019 | Нийт 30 оюутанд 900 мянган төгрөгийн тэтгэлэг олгосон. | Оюутнуудад сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох журамд өөрчлөлт оруулж, орон нутагт нэн шаардлагатай, эрэлттэй 6 салбарын 13-н мэргэжлээр суралцаж буй оюутанд тэтгэлэг олгохоор тусгаж, 2021 оны А/247 дугаар захирамжаар “Орон нутагт дутагдалтай мэргэжлээр суралцаж буй оюутанд аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгох журам”-ыг батлуулсан.<br>Тэтгэлгийг 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл 3 удаа хугацааг сунган, материалыг хүлээн авсан.<br>Нийт 11 материал ирснээс журмын шалгуурыг хангасан 4 оюутны /бага ангийн багш, гадаад хэлний багш, их эмч, нийгмийн эрүүл мэнд/ сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэгт хамруулан, хүний нөөцийн дутагдалтай салбарт ажиллуулахаар гэрээ байгуулж, 12 дугаар сарын 09-ний өдөр батламжийг гардуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Тэтгэлэгт хамрагдсан оюутны тоо-4 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Хэрэгжилт 100 хувь** |
| 2.3.7 Ерөнхий боловсролын сургууль бүр стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцтэй болсон байна. | | | | | | |
| 30 | Ерөнхий боловсролын сургууль бүр хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцөөр хангагдана. | 35.0 | “Үдийн хоол” хөтөлбөрийг бага ангид хэрэгжүүлнэ.<br><br>Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах сургуулийн тоо-1<br><br>Бэлтгэх хоол, хүнсний мэргэжилтний тоо-5 | 2019 | Үдийн цай хөтөлбөрийг АНБ-тай гэрээгээр гүйцэтгүүлсэн. | Аймгийн хэмжээнд Ерөнхий боловсролын 5-н сургууль үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна.<br><br>Үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах зорилгоор АОНХС-ийн 32.9 сая төгрөгийн хөрөнгөөр Ерөнхий боловсролын лаборатори 5 дугаар сургуульд 7 нэр төрлийн /1, 2 дугаар хоолны тогоо, плитка, шарах шүүгээ, махны машин, хөлдөөгч, дээжний хөргүүр, хоол бэлтгэлийн ширээ/, Сүмбэр сумын ОНХС-ийн 25.0 сая төгрөгөөр Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд 10 нэр төрлийн /1, 2 дугаар хоолны тогоо, хөргөгч, хөлдөөгч, шарах шүүгээ, буузны жигнүүр, аяга таваг хатаагч, тосгуурт аяга угаагч, махны машин, дээжний хөргөгч/ гал тогооны тоног төхөөрөмжөөр тус тус хангасан.<br><br>Боловсрол, шинжлэх ухааны яамнаас зохион байгуулсан “Хоол, үйлдвэрлэл үйлчилгээний ажилчдыг мэргэшүүлэх сургалт”-нд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эмч, тогооч, нярав нийт 37 албан хаагчдыг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>“Үдийн хоол” хөтөлбөрийг бага ангид хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан сургуулийн тоо-2<br>Бэлтгэгдсэн мэргэжилтний тоо-1<br>**Хэрэгжилт 73.3 хувь** |
| 2.3.8 Яслид 1-2 насны хүүхдийг, сургуулийн өмнөх боловсролд 3-5 насны хүүхдийг, үүнээс 5 настай хүүхдийг бүрэн хамруулж, сургуульд суралцах бэлтгэлийг хангана. | | | | | | |
| 31 | Хүүхэд харах үйлчилгээг нэмэгдүүлэн, 5 дугаар цэцэрлэгт яслийн бүлэг байгуулна. | 50.0 | Хүүхэд харах үйлчилгээний тоо- 1<br><br>Яслийн бүлгийн тоо-1<br><br>Хамрагдах хүүхдийн тоо-15 | 2019 | 1 хүүхэд харах үйлчилгээнд 5 хүүхэд хамрагдаж, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ эзэмшсэн. | Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгт шинээр яслийн бүлэг нээхээр бэлтгэл ажлыг хангаж, яслийн 1 багш, 1 сувилагчийг бэлтгэсэн. Ковидын нөхцөл байдлын улмаас яслийн бүлэг болон хүүхэд харах үйлчилгээ ажиллаагүй. Орон нутагт 1 хүүхэд харах үйлчилгээ байгаа боловч, ковидын нөхцөл байдлаас шалтгаалан үйл ажиллагаа явуулаагүй.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Хүүхэд харах үйлчилгээний тоо-1<br>Яслийн бүлгийн тоо-1<br>Яслийн бүлэгт хамрагдсан хүүхдийн тоо-0<br>**Хэрэгжилт 66.7 хувь** |
| 2.3.9 Насан туршийн боловсролын төвийг байгуулж, үйл ажиллагааг өргөжүүлнэ. | | | | | | |
| 32 | Бүх насны иргэд тасралтгүй суралцах нөхцөлийг бүрдүүлж, насан туршийн боловсролын төвийг бие | | Насан туршийн боловсролын төв байгуулан бүтэц зохион байгуулалтыг | 2019 | Ерөнхий боловсролын 1 дүгээр | Бүх насны иргэдэд тасралтгүй суралцах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2021 оны А/305 дугаар захирамжаар “Насан туршийн боловсролын төв”-ийг байгуулан, 2021 оны төсвийн тодотголоор 2 албан хаагчийн цалин санд 11.3 сая төгрөгийг шийдвэрлэж, ажлын байраар ханган үйл |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | даасан байр, танхимтай болгоно. | | шинэчилнэ. | | сургуулийг түшиглэсэн хэлбэрээр 2 багш насан туршийн боловсролын үйлчилгээг явуулж байна. | ажиллагааг явуулж эхлээд байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Насан туршийн боловсролын төвийн бүтэц зохион байгуулалтыг шинэчилсэн.<br>Орон нутгийн төсөвт шаардлагатай төсвийг батлуулсан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.3.10 Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, Монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх шатны боловсролын байгууллагад хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 33 | Орон нутгийн өв соёл, зан заншил, Монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн "Тост Боржигин", "Боржигин өв соёл" сургалтын хөтөлбөрийг цэцэрлэг, сургууль бүрд хэрэгжүүлнэ. | | Сургалтын хөтөлбөрийг 2 сургууль, 2 цэцэрлэгт хэрэгжүүлнэ.<br><br>Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь-100 | 2019 | Тост Боржигин" , "Боржигин өв соёл" сургалтын хөтөлбөрийг 1 цэцэрлэг, 1 сургуульд хэрэгжүүлж байна. | Аймгийн ерөнхий боловсролын лаборатори 5 дугаар сургууль нь бага ангийн сурагчдад танхимын бус үед "Боржигин соёлоос суралцацгаая" хөтөлбөрийн хүрээнд UBL.mn платформд суурилан цахимаар жороо үг, оньсого, зүйр үг, түргэн хэллэг, хэлц үгийг 1200 хүүхдүүдэд сургаж, танин мэдүүлэх, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулсан.<br>Мөн Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн "Тост Боржигин" хөтөлбөрийн хүрээнд цахим хичээл 122, 40 интерактив хичээлүүдийг бэлтгэн нийт давхардсан тоогоор 560 хүүхдэд хүргэсэн.<br>Ардын наадам, ардын тоглоом тоглох, сөөх нийлүүлэх арга, 3 модны борх зэрэг ардын ёс заншлаас явуулын богцоор 68 өрхөд аялуулснаар 220 хүүхдүүд ардын ёс заншлаас суралцсан. "Гэрэлт нарны хүүхдүүд" тайлант өдөрлөгийг нийт 200 хүүхдийн хүрээнд зохион байгуулсан.<br>"Тост боржигин" хөтөлбөрийг цахим хэлбэрт шилжүүлэн сургууль, цэцэрлэгийн группд байршуулан олны хүртээл болгож байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн сургууль-1<br>Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн цэцэрлэгийн тоо-1<br>Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь-50 хувь<br>**Хэрэгжилт 50 хувь** |
| **Зорилтын дундаж үнэлгээ** | | | | | | **82.6 хувь** |
| **Шинжлэх ухаан, технологи, инновац** | | | | | | |
| **2.4. Орон нутагт стандартчилал, хэмжил зүйн нэгж байгуулна.** | | | | | | |
| 2.4.1. Орон нутагт стандартчилал, хэмжил зүйн нэгж байгуулна. | | | | | | |
| 34 | Орон нутагт стандартчилал, хэмжил зүйн нэгж байгуулна. | | Орон нутагт стандартчилал хэмжил зүйн нэгж байгуулах төсөв хөрөнгийг шийдвэрлүүлнэ. | 2019 | | Дорноговь аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтэстэй хамтран орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа 17 аж ахуйн нэгжийн тохирлын гэрчилгээг сунгасан.<br>Орон нутагт стандартчилал хэмжил зүйн нэгж байгуулах хүсэлтийг Шадар сайд, Дорноговь аймгийн стандартчилал хэмжил зүйн хэлтэст хүргүүлсний дагуу манай аймагт стандартчилал хэмжил зүйн нэгж байгуулахаар ажлын хэсэг байгуулаад байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Хүрсэн түвшин:**<br>Холбогдох дээд байгууллагуудад уламжилсан.<br>**Хэрэгжилт 50 хувь** |
| 2.4.2. Судалгаа, шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудтай хамтран орон нутгийн түвшинд судалгаа, шинжилгээний ажлуудыг хийж, инновацыг нэвтрүүлэхийг бодлогоор дэмжинэ. | | | | | | |
| 35 | Судалгаа, шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудтай хамтран орон нутгийн түвшинд судалгаа, шинжилгээний ажлуудыг хийж, инновацыг нэвтрүүлэхийг бодлогоор дэмжинэ. | | ШУА-ийн Газар зүй - геоэкологийн хүрээлэнтэй хамтран 22 га талбайд говь цөлд ургадаг бутлаг ургамлыг тарих судалгаа шинжилгээний ажил хийнэ. | 2019 | ХААИС-тай хамтран 4 га газарт орон нутгийн онцлогт тохирсон бутлаг ургамал тарих судалгаа шинжилгээний ажил хийгдсэн. Мөн ШУА-ийн Газар зүй - геоэкологийн хүрээлэнтэй хамтран 22 га талбайд говь цөлд ургадаг бутлаг ургамлыг тарих судалгаа шинжилгээний ажил хийгдэж байна. | Цөлжилтөөс хамгаалах ганд тэсвэртэй модлог ургамал тарималжуулж турших зорилгоор олон хувилбарт туршилт судалгааны ажлуудыг 2019 оноос явуулж байна. Туршилтын 1-р талбайд 11 эгнээнд 550, салхинаас хамгаалах ойн зурваст 100, нийт 650 жигд, хармаг, монгол азар, сухай, заг зэрэг төрөл зүйлийн суулгац, туршилтын 2-р талбайд 600 мод сөөгийн суулгац тус тус тариалсан. 2020 онд ганд тэсвэртэй 10 төрлийн 1000 гаруй мөчир, 10 кг хонхорт харганы үр, 2000 хайлаас суулгацаар тарьсан. 2022 онд хайлаас 5000, улиас 1000, сухай мөчир 5000, төрөл бүрийн үр 20 кг тус тус тарихаар бэлтгэл ажил хангасан. Газар зүй - геоэкологийн хүрээлэнгээс дээрх судалгааны ажлын дүгнэлтийг 2021 онд гаргаагүй болно.<br>**Хүрсэн түвшин:**<br>Гандуу бүс нутагт мод сөөг тарих арга зүйн зөвлөмжүүд боловсруулагдсан. Цаашид уг төвийн үйл ажиллагааг нь өргөжүүлэн Говийн бүсийн инновaци дамжуулах төв болгох зорилт дэвшүүлэн ажиллаж байна.<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| **Зорилтын дундаж үнэлгээ** | | | | | | **70.0 хувь** |
| **Хөдөлмөр, нийгмийн хамгаалал** | | | | | | |
| **2.5. Хүн амын хөгжлийг хангаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл ядуурлыг бууруулна.** | | | | | | |
| 2.5.1. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох, судалгаанд үндэслэн нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэнэ. | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 36 | Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэнэ. | 3,052.3 | Зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэсэн байна. | 2019 | Зорилтот бүлгийн иргэдэд 2252.2 сая төгрөгийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн. | Нийгмийн халамжийн үйлчилгээг 2021 онд 2580 иргэнд хүргэж, 767,421.1 мянган төгрөгийг олгосон. Үүнд:<br>- Нийгмийн халамжийн тэтгэврийг 253 иргэнд 178,271.8 мян.төг;<br>- Асаргааны мөнгөн тэтгэмжийг 275 иргэнд 222,637.5 мян.төг;<br>- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж 249 иргэнд 185,992.2 мянган төгрөг;<br>- Ахмад настны хөнгөлөлт, тусламжийг 829 иргэнд 57,667.3 мян.төг;<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжийг 230 иргэнд 43,509.9 мянган төгрөг;<br>- ОНОТХҮ-ний Сэргээн засах үйлчилгээнд 60 иргэнд 11,120.0 мянган төгрөг;<br>- Хүнс тэжээлийн дэмжлэг, тусламжийг 673 иргэнд 79,521.9 мянган төгрөгийг тус тус олгосон.<br>Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд үндэслэн дараах тэтгэмжийг олгосон. Үүнд:<br>- Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжийг 11 иргэнд 13,200.0 мянган төгрөгийг;<br>- Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 6966 хүүхдэд олгосон.<br>Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдахаар нийт 107 өрхийн өргөдлийг хүлээн авсан бөгөөд шийдвэрлэсэн 62 өрх, уламжилсан /тулгалт, баталгаажуулалт хийгдэх/ - 45 өрх байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Халамжийн үйлчилгээ авсан иргэдийн тоо-2580<br>Үйлчилгээтэй холбоотой гомдол санал гараагүй.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.5.2. Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | | | | | | |
| 37 | Ажилгүй ажил олоход хүндрэлтэй иргэдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | 6.8 | Иргэдийн ажил эрхлэлт, амьжиргааны түвшингийн судалгаа хийнэ.<br><br>Мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамрагдсан иргэний тоо -30<br><br>Хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамрагдсан иргэний тоо-40<br><br>Орлого нэмэгдсэн өрхийн тоо-35 | 2019 | Мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамрагдсан иргэний тоо -31<br><br>Хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамрагдсан иргэний тоо-48 | “Нэг өрх-Нэг ажлын байр” арга хэмжээний хүрээнд Сүмбэр сумын 1,2,3 дугаар багийн 816 өрхөөс өрхийн нөхцөл байдлын судалгааг авч, өрхийн нөхцөл байдлыг сайжруулах ажлыг үе шаттайгаар хийхээр төлөвлөж байна. Судалгаанд хамрагдсан өрхийн 35.5 хувь нь ажил эрхэлдэг, 27.2 хувь нь ажилгүй, 9.6 хувь нь малчин, 13.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 1.8 хувь нь улирлын чанартай ажил эрхэлдэг, 1.1 хувь нь албан бус хөдөлмөр эрхэлдэг байна.<br><br>Политехник коллежтой хамтран мэргэжлийн боловсрол олгох 1 жилийн ангид ажилгүй 5 иргэнийг “Хангамжийн нярав”, “Металл боловсруулах машины оператор /Токарь, фрезер/” мэргэжлээр, ажилгүй 5 иргэн 14 хоногийн гагнуурын мэргэжлийн сургалтад хамруулж, мэргэжлийн үнэмлэхтэй болгосон.<br><br>Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх арга хэмжээг ганцаарчилсан, бүлгээр /цахим хэлбэр/ зохион байгуулж, 327 иргэнийг хамруулж зардалд 748,2 мян.төг зарцуулсан. Үүнд: |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • **Ганцаарчилсан** зөвлөгөө өгөх үйлчилгээнд**:** 240 иргэнийг *(үүнээс эмэгтэй-153, нийгмийн халамжийн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг -57)* хамруулж, зардалд 226,2 мян төг зарцуулсан.<br>• **Бүлгээр** зөвлөгөө өгөх үйлчилгээнд: Нийгмийн халамжийн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг ажил хөдөлмөр эрхлээгүй - 87 */Сүмбэр -42, Шивээговь -29, Баянтал -16/* иргэнд “Девелопмент консалтинг” сургалтын байгууллагатай хамтран ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулж, ажлын байран дахь харилцаа сэтгэл зүйн сургалт, ажил мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ мэдээллийг өгч хамруулсан.<br>Хувиараа бичил бизнес, өрхийн аж ахуй эрхлэх, хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 65 (үүнээс хөгжлийн бэрхшээлтэй-8) иргэнд “Хөгжлийн шийдэл”, “Жи Эс Эм” эрх бүхий сургалтын байгууллагуудтай хамтран бизнесийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг танхим, цахим хэлбэрийг хослон зохион байгуулж, зардалд 1950,0 мян төг зарцуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Иргэдийн ажил эрхлэлт, амьжиргааны түвшингийн судалгаа хийсэн.<br>Мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамрагдсан иргэний тоо-10<br>Хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамрагдсан иргэний тоо-87<br>Дээрх сургалтад хамрагдаж, хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрт хамрагдаж орлого нь нэмэгдсэн өрхийн тоо- 40<br>**Хэрэгжилт 83.3 хувь** |
| 2.5.3. Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулж, шинээр баригдаж байгаа зам, талбай, барилга, байгууламжид саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | |
| 38 | Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулж, шинээр баригдаж байгаа зам, талбай, барилга, байгууламжид саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ. | | Шинээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын ажлуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг бүрэн тусгана.<br><br>Аж ахуйн нэгж, албан байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авах орчныг бүрдүүлнэ. | 2019 | Шинээр баригдаж буй 2-р сургууль, 5 цэцэрлэг, аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг бүрэн тусгасан. Төрийн | 2021 онд шинээр боловсруулсан 7 барилгын зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц, ариун цэврийн өрөөг төлөвлөж батлуулсан.<br><br>Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх, судалгаа мэдээлэлтэй болох, тодорхой арга хэмжээ авах ажлыг зохион байгуулахаар аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/107 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний судалгаа гарган, олон нийтийн зориулалттай 30 барилгад үзлэг шалгалт хийж, зөвлөгөө дэмжлэг өгч, барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөллийг оролцуулж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын ажлуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг тусгасан байдал, хувь – 100 хувь<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авах орчныг бүрдүүлсэн аж ахуйн нэгж, албан байгууллагын тоо – 3 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | банкны Сүмбэр тооцооны төв хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авах орчныг бүрдүүлсэн. | **Хэрэгжилт 90 хувь** |
| 2.5.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэн, 1000-аас доошгүй иргэдийг байнгын, 1200-аас доошгүй иргэдийг түр ажлын байраар хангана. | | | | | | |
| 39 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэн иргэдийг ажлын байраар хангаж, ядуурлыг бууруулна. | | Байнгын ажлын байр-250-аас доошгүй<br><br>Түр ажлын байр -300-аас доошгүй | 2019 | Байнгын ажлын байранд 204, түр ажлын байранд 199 иргэнийг зуучилсан. | - Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр 5 хөтөлбөрийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн хүрээнд 44 иргэнд байнгын ажлын байр бий болгоход 175,000.0 мян.төгрөгийн дэмжлэгийг олгосон.<br>- ДЗОУБ-ын дэмжлэгээр 30 байнгын ажлын байр бий болсон.<br>- Ажил олгогчоос 42 байнгын ажлын байр бий болсон.<br>- Ажил олгогчдоос ирсэн зарын дагуу 429 иргэнийг зуучилсан.<br>**Түр ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр** ХЭД хөтөлбөрүүдийн хүрээнд 12 ажил олгогч байгууллагатай хамтран ажилгүй, ажил олоход хүндрэлтэй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, түр ажлын байр бий болгох төслийг хэрэгжүүлж, 143 түр ажлын байр бий болгож, цалин урамшуулал, ХАБЭА-н зардалд 41536,0 мян.төг зарцуулсан. 1 иргэний өрхийн орлого дунджаар 245.0-305.0 мян.төгрөгөөр нэмэгдсэн. Ахмадын зөвлөх үйлчилгээ-14, Хүүхэд хамгаалагч төсөл-4, Ажил олгогчид 23 түр ажлын байр тус тус бий болсон. Мөн Монгол улсын Засгийн газраас зарласан “Ажлын байрыг дэмжих 2 их наяд төгрөгийн зээл”-ийг 153 аж ахуй нэгж байгууллагад 14.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосноор 75 түр ажлын байр бий болсон.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр бий болсон байнгын ажлын байрны too - 116<br>Шинээр бий болсон түр ажлын байрны тоо – 260<br>**Хэрэгжилт 66.6 хувь** |
| 2.5.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, зорилтод бүлгийн иргэдийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 40 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, зорилтод бүлгийн иргэдийг дэмжих арга хэмжээ хэрэгжүүлнэ. | 15.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 | | | “Жендерийн эрх тэгш байдлыг хангах, зорилтод бүлгийн иргэдийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөө”-г батлуулан, 9 арга хэмжээ төлөвлөн, 87.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.<br>Зохион байгуулсан ажлаас дурдвал:<br>- “Буянт буурлуудаа хүндэлье” сарын аяныг зохион байгуулж, байнгын асаргаа шаардлагатай 42 ахмад настанд дархлаа дэмжих багц өгч, 1.3 сая төгрөгийг зарцуулсан.<br>- “Цагаан таягтны өдөрлөг”-өөр харааны бэрхшээлтэй 10 хүнд дархлаа |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэмжих багц өгч 986550 төгрөг зарцуулсан.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд цахим уралдаан зарлаж 305000 төгрөг зарцуулсан.<br>- “Эрүүл Монгол-Эр хүн” уриан дор эрэгтэйчүүдийн II зөвлөгөөн зохион байгуулж 1.160.0 төг зарцуулсан.<br>- Хувь хүний хөгжлийн институт, Аймгийн эмэгтэйчүүдийн холбоотой хамтран “Эмэгтэйчүүдийн манлайлал ба хөгжил” сэдвээр сургалт зохион байгуулж 827.500 төг зарцуулсан.<br>- "Зүүний хүчний холбоо" ТББ-тай хамтран "Жендэр ба хүний эрх" сэдвээр төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулж 902.650 төгрөг зарцуулсан.<br>- Монголын ахмадын байгууллагын 90 жил, Говьсүмбэр аймгийн Ахмадын хорооны 30 жилийн ойн нэрэмжит спортын уралдаан, тэмцээнийг Ахмадын хороотой хамтран зохион байгуулж 1.0 сая төг зарцуулсан.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд гэрийн эргэлтээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд 1.0 сая төг зарцуулсан.<br>- "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан "Өөдрөг зөвлөл" холбоо ТББ-тай хамтран "Бид Монгол улсын тэгш дүүрэн иргэд" урлагийн наадмыг зохион байгуулж 735.000 төг зарцуулсан.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын тэмцээнийг зохион байгуулж 630.000 төг, УАШТ-д оролцогчдын зардалд 825.600 төг зарцуулсан. Мөн багийн тамирчдын өмсгөлийн зардал болох 440.000 төг Засаг даргын нөөцийн хөрөнгөөс шийдэж УАШ-д явах баг тамирчдаа дэмжиж ажилласан.<br>**Хэрэгжилт 87.7 хувь** |
| 2.5.6. Ахмадын өргөөний барилгыг шинээр барьж, ахмад настны хөгжлийн төвийг байгуулна. | | | | | | |
| 41 | "Ахмадын өргөө"-ний барилгыг шинээр барьж, ахмад настны хөгжлийн төвийг байгуулан, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | 39.0 | Зураг төсвийг гүйцэтгүүлнэ. | 2019 | Ахмадын төвд 25.0 төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч өгсөн. | "Ахмадын өргөө"-ний барилгын зураг төслийн ажлыг Аслаан ХХК-аар гүйцэтгүүлж байна.<br>**Хүрсэн түвшин:** Зураг төслийн ажлын гүйцэтгэлийн хувь-90 хувь<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 2.5.7. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна. | | | | | | |
| 42 | Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна. | | Мэдээллийн баазтай болсон байна. | 2019 | Хяналт шалгалтын тоо-2, Зөрчлийг арилгасан байдал 100 хувь | Аймгийн хэмжээнд албан бус хөдөлмөр, эрхлэлтийн бүртгэл мэдээллийг сайжруулах, мэдээллийн сан бий болгох зорилтын хүрээнд зах худалдааны төвд хувиараа бизнес эрхэлдэг иргэдэд албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх ойлголт, мэдээллийг өгч, албан хэлбэрт шилжихийн ач холбогдлын талаар арга зүйн зөвлөгөө өгч, 14 албан бус хөдөлмөр эрхлэгч иргэний мэдээллийг мэдээллийн санд бүртгэсэн.<br>Аймгийн хэмжээнд албан бус хөдөлмөр эрхлэгч 2020 оны байдлаар ХАА-н салбарт 3033 иргэн, /эр -1451, эм –1572/ ХАА-н бус салбарт - 552 иргэн /эр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -264, эм – 288/ иргэн бүртгэгдсэн байна.<br>2021 оны албан бус хөдөлмөр эрхлэгчийн статистик тоон мэдээ /1212.mn/ гараагүй байна.<br>**Хүрсэн түвшин:** Мэдээллийн санг бүрдүүлсэн.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.5.8. Иргэдийн сайн дурын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 43 | Сайн дурын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | | Сайн дурын даатгал 650 иргэн хамрагдсан байна | 2019 | Сайн дурын даатгал 610 иргэн хамрагдсан | Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 2021 оны эцсийн байдлаар оюутан 12, малчин 128, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн 71, ажил эрхлээгүй 330, гадаадад оршин суугаа иргэн 37, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа иргэн 130 нийт 708 иргэн даатгуулагч хамрагдан нийгмийн даатгалын санд 190,500.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна. Энэ онд шинээр 140 иргэн хамруулахаас 170 иргэн хамрагдсан байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сайн дурын даатгалд 708 иргэн хамрагдсан байна.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.5.9. Уул уурхайн жишиг Политехникийн коллежийг түшиглэн орон нутгийн иргэдийг мэргэшүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулна. | | | | | | |
| 44 | Орон нутагт суурь боловсрол эзэмшигчдийн 30 хувийг Политехник коллежид элсүүлэн суралцуулах, орон нутгийн ажилгүй иргэд, амьжиргааны түвшинээс доогуур орлоготой өрхийн болон олон хүүхэдтэй өрхийн хүүхдэд МБС-ын байгууллагаар дамжуулан мэргэжил эзэмшүүлнэ. | | Мэргэжил эзэмшсэн иргэдийн тоо -50 | 2019 | Аймгийн ерөнхий боловсролын сургуулийг төгссөн 44 суралцагч суралцаж байна. | Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийг төгссөн 46 хүүхэд 2020-2021 оны хичээлийн жилд мэргэжлийн боловсрол сургалтын 2.5 жилийн ангид 5 мэргэжлээр суралцаж байна. Үүнд:<br>• Авто машины засварчин 11<br>• Барилгын цахилгаанчин 13<br>• Барилгын засал чимэглэлчин 8<br>• Гагнуурчин 8<br>• Уул уурхайн нөхөн сэргээлт 6<br>Мэргэжлийн боловсрол сургалтын 1 жилийн ангид ажилгүй 5 иргэн “Хангамжийн нярав”, “Металл боловсруулах машины оператор /Токарь, фрезер/” мэргэжлээр суралцан мэргэжлийн үнэмлэхтэй төгсч байна.<br>Гагнуурчин мэргэжлийн богино хугацааны сургалтаар ажилгүй 5 иргэн 14 хоногийн сургалтад хамрагдаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Политехникийн коллежид орон нутагт суурь боловсрол эзэмшсэн 46 хүүхэд мэргэжлийн боловсролын суралцаж байна.<br>Мэргэжлийн үнэмлэх олгох сургалтад ажилгүй 10 иргэн суралцсан<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **Зорилтын дундаж үнэлгээ** | | | | | | **90.8 хувь** |
| **Үндэсний бахархал, өв соёл** | | | | | | |
| **2.6. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.** | | | | | | |
| 2.6.2. Боржигин чуулгын барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна. | | | | | | |
| 29 | Дуу бүжгийн Боржигин чуулгын шинэ барилгыг барина. | 1,134.0 | Боржигин чуулгын барилгын ажлыг эхлүүлнэ. | | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дуу бүжгийн Боржигин чуулгын 400 хүний суудалтай барилгын ажлыг “Хөшиг уул ХХК-тай гэрээ байгуулан эхлүүлсэн. 2021 онд 1134.0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэсэн.<br>**Хүрсэн түвшин:** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Боржигин чуулгын барилгын ажлыг эхлүүлж, суурийн ажил 75 хувьтай хийгдэж байна.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.6.3. Соёл урлагийг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 31 | Соёл, урлагийг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 10.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 | | | Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 6 арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:<br>- “Угийн бичиг хөтлөх арга зүй” анхан шатны 3 удаагийн цахим сургалтад 476 иргэнийг, танхимаар 26 байгууллагын 601 албан хаагчийг хамруулсан. Мөн 150 малчин, 30 ахмад настан, 23 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 355 хүүхдэд сургалт зохион байгуулж, нийт 1455 иргэнд угийн бичиг хөтлөх мэдлэг олгосон.<br>- Аймгийн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын хоёрдугаар зөвлөгөөнийг зохион байгуулж, 81 өвлөн уламжлагч оролцлоо.<br>- “**НОМЫН БАЯР 2021”** цахим арга хэмжээг зохион байгуулж, 17 цахим контент бэлтгэн, 820 иргэнд хүргэсэн.<br>- “Хөглөхүй” хөгжим ангийн тоглолтод зориулж хөгжимчдийн дээл, хөгжмийн хэрэгслийг солих ажилд дэмжлэг үзүүллээ.<br>- Аймгийн Засаг даргын 2021 оны А/380 дугаар захирамжаар түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг зохион байгуулсан. Тооллогоор 83 газрын 616 дурсгалыг бүртгэж RICH программд бүртгэн оруулаад байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дугаар тушаалаар Зараагийн зүүн өврийн хүн чулуу, Зүүн Чойр хийдийн туурь, Дагвасүндэл бурхныг аймгийн хамгаалалтад авсан. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг Чойрын богд ууланд байрлах Дагвасүндэл бурхныг улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлээр баталсан.<br>- “Соёлын цаг” аяны хүрээнд аймгийн есөн гайхамшиг, түүх соёлын үл хөдлөх дурсгал, байгалийн үзэсгэлэнт газрууд, баримтат өв, монгол тоглоом наадгайг сурталчлах 11 ширхэг стикер самбар, 35 ширхэг үзүүлэн самбар хийлгэж үзэсгэлэнгийн материал бэлтгэсэн. Мөн нүүдлийн үзэсгэлэн, явуулын цахим музей /VR box/, соёлын үйлчилгээг нийт 781 иргэд үзүүлсэн.<br>- Аймгийн Дуу Бүжгийн Боржигин чуулгад шинээр 6 тоглолтыг зохион байгуулсан.<br>- “Соёлын цаг” “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд “БИЧИГ СОЁЛ-ЭД ӨЛГИЙН ЗҮЙЛИЙН ҮЗЭСГЭЛЭН” гаргаж, “ӨДӨР БҮР УНШЪЯ” ном уншлагын уралдаанд нийт 85 уншигч хамрагдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.6.4. Соёлын биет бус өвийг тусгасан уран бүтээлүүдийг туурвихад дэмжлэг үзүүлж, хөдөөгийн багийн иргэдэд явуулын соёлын үйлчилгээг үзүүлнэ. | | | | | | |
| 32 | Соёлын биет бус өвийг | | Боржигин өв соёл, | 2019 | Боржигин | Соёлын бүтээлч сар аяны хүрээнд Боржигин өв соёлыг сурталчилсан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тусгасан уран бүтээлүүдийг туурвихад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. | | түүхийг харуулсан бүрэн хэмжээний концертын бүтээл туурвина. | | чуулгын урын санг 3 бүтээлээр нэмэгдүүлсэн. /"Мөрөөдлийн ертөнцөөр" хүүхдийн концерт, Үндэсний урлаг үргэлжлэхгүй түүвэр тоглолт, Зүрхнээс эгшиглэх хөг хөгжмийн концерт/ | бүрэн хэмжээний концертыг дэглэн, "Жинчид ирлээ" Ардын дууны тоглолт, "Хөглөхүй Хөгжим" ангийн уран бүтээлчдийн тоглолт, "ЗАЯА ДААСАН НУТАГ", "Яруу эгшиг" Дуу ангийн уран бүтээлчдийн тоглолт "Хэлэмж" Бүжиг ангийн уран бүтээлчдийн тоглолт, "Мэргэжил бүхэн сайхан" Контентын оролцогчдын нэгдсэн тоглолт зэрэг 6 уран бүтээлийг үзэгчдэд хүргэхээр бэлтгэлийг бүрэн хангаж, үзэгчдэд хүргэж эхэлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Боржигин өв соёлыг сурталчилсан бүрэн хэмжээний концертыг дэглэсэн.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 33 | Хөдөөгийн багийн иргэдэд явуулын соёлын үйлчилгээг үзүүлнэ. | | Явуулын соёлын үйлчилгээний тоо-2<br><br>Хамрагдах хүний тоо - 2000 | 2019 | Явуулын соёлын үйлчилгээг 3 сумын 10 багийн 6719 иргэнд хүргэсэн. Нийт 3.1 сая төгрөг зарцуулсан. | Сүмбэр сумын хөдөөгийн багт явуулын соёлын үйлчилгээг 2 удаа зохион байгуулж, 168 иргэнийг явуулын VRBOX-оор музейн үзмэртэй танилцуулж, 150 малчин иргэнийг угийн бичгийн анхан шатны сургалтад хамруулж, соёлын өвийг сурталчлах 14 төрлийн 494 ширхэг гарын авлага материалыг тарааж, мэдээлэл хүргэн ажилласан. Явуулын соёлын үйлчилгээний хүрээнд Сүмбэр сумын хөдөөгийн багийн 15, Баянтал сумын хөдөөгийн багийн 8, Шивээговь сумын хөдөөгийн багийн 8, нийт 31 иргэнд 160 ширхэг ном, хэвлэлийг хүргэсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Явуулын соёлын үйлчилгээний тоо -2<br>Хамрагдсан иргэдийн тоо - 843<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| 2.6.5. Орон нутагт соёл, урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг чадавхжуулна. | | | | | | |
| 34 | Орон нутагт соёл, урлагийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг чадавхжуулна. | | Соёлын хэлтэс байгуулна. | | | Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 25-ны А/238 дугаар захирамжаар Соёлын хэлтэс байгуулан, дүрэм бүтцийг баталж, аймгийн Засаг даргын 2021 оны Б/16 захирамжаар хэлтсийн даргыг томилон, үйл ажиллагааг эхлүүлээд байна.<br><br>Орон нутгийн соёлын ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах зорилгоор Соёлын яам, Соёл урлагийн их сургуультай хамтран зохион байгуулсан сургалтад соёлын төвийн дарга, ажилтнууд хамрагдсан. Соёлын яамнаас зохион байгуулсан соёлын ажилтнуудыг чадавхжуулах сургалтад соёл, урлагийн байгууллагын 3 удирдах ажилтан, 5 мэргэжилтэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамрагдсан.<br>Орон нутгийн соёлын ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах зорилгоор Соёлын яам, Соёл урлагийн их сургуультай хамтран зохион байгуулсан мэргэжил дээшлүүлэх 7 хоногийн сургалтад танхимаар 10 ажилтан, цахимаар Боловсрол соёл урлагийн газрын мэргэжилтэн, соёл урлагийн байгууллагуудын удирдах ажилтан, албан хаагч нийт 27 хүн хамрагдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Соёлын хэлтсийг байгуулсан.<br>Сургалтад хамрагдсан хүний тоо-45<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.6.6. Соёл урлагийн байгууллагуудын орчин, нөхцөлийг сайжруулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана. | | | | | | |
| 35 | Боржигин өв музей, Нийтийн номын сангийн байрыг засварлана. | 16.0 | Засварын зураг төсвийг хийлгэнэ. | | | Музей, Номын сангийн барилгын их засварын зураг төсвийг “Эрхэс констракшн” ХХК –аар гүйцэтгүүлэн, хүлээн авсан.<br>Музей, Номын сангийн барилгын их засварын ажлын төсвийг 2022 оны улсын төсөвт тусгуулах саналыг салбарын болон Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсөвт тусгагдаагүй.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.6.7. Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчид болон төрийн байгууллагуудын албан хаагчдын Монгол хэл, бичгийн чадварыг дээшлүүлж, уламжлалт Монгол бичгийг албан хэргийн түвшинд ашиглаж эхэлнэ. | | | | | | |
| 36 | Төрийн байгууллагын албан хаагчдыг Монгол бичгийн сургалтад хамруулж, хуучин Монгол бичгээр унших, бичих чадавхыг сайжруулж, албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр явуулж эхэлнэ. | 3.0 | Зохион байгуулсан сургалтын тоо-5<br><br>Нийт төрийн албан хаагчдын 50 хувийг сургалтад хамруулна. | | | Аймгийн хэмжээний нийт төрийн албан хаагчдын үндэсний бичгийн түвшин тогтоох судалгаа авч, анхан шатны Монгол бичгийн сургалтыг Төрийн захиргааны байгууллагуудын албан хаагчдыг хамруулан зохион байгууллаа. Түвшин тогтоох судалгаанд нийт 1189 албан хаагч, үүнээс төрийн улс төрийн 51, төрийн захиргааны 207, төрийн тусгай 34, төрийн үйлчилгээний 897 албан хаагчийг судалгаанд хамруулсан бөгөөд судалгаанд хамрагдсан албан хаагчдын 58 буюу 4.9 хувь нь маш сайн, 164 буюу 13.8 хувь нь сайн, 299 буюу 25.1 хувь нь дунд зэрэг, 285 буюу 24 хувь нь бага зэрэг, 383 буюу 32.2 хувь нь мэдлэггүй гэж үнэлэгдсэн. Төрийн захиргааны албан хаагчдыг 11 сэдвийн хүрээнд 5 баг болгон сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж байна. Сургалтад төрийн 52 байгууллагын төрийн захиргааны 177, бичиг хэргийн 52 ажилтан, нийт 229 албан хаагчийг хамруулж, ОНХС-аас 3.0 сая төгрөг зарцуулсан.<br><br>Төрийн албан хаагчдад монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох, ур чадварыг сайжруулах зорилгоор лаборатори 5 дугаар сургуулийн монгол бичгийн багшийн бэлтгэсэн гарын авлагыг Засаг даргын нөөц хөрөнгөөс 2.5 сая төгрөгөөр 1000 ширхэг гарын авлагыг хэвлүүлж, төрийн албан хаагчдын хэрэгцээнд тарааж, ур чадварыг сайжруулах ажлыг хийж байна.<br><br>Төрийн албан хаагчид болон багш нар өөрийн сурч мэдсэн зүйлсээрээ Flipsnack.com ашиглан цахимаар унших ном хийн 3200 иргэнд түгээсэн.<br>Монгол хэл бичгийн багш нарт, цахим орчинд бичмэл дармалаар бичих сургалтыг зохион байгуулсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Хүрсэн үр дүн:**<br>Зохион байгуулсан сургалтын тоо- 11<br>Нийт хамрагдсан төрийн албан хаагчдын тоо: Төрийн захиргааны 177 албан хаагч<br>Хамрагдалтын хувь: 85.5 хувь<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 37 | Монгол бичгийг иргэдэд сурталчлан түгээн дэлгэрүүлнэ. | | Зохион байгуулах арга хэмжээний тоо-2 | | | Хэлний бодлогын зөвлөлийн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, Монгол бичгийг иргэдэд сурталчлах түгээн дэлгэрүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:<br>1. Монгол Улсын Гавьяат багш Н.Түмэн-Өлзийн нэрэмжит 18 дахь удаагийн ‘’Үндэсний бичиг бидний өв -2021 ‘’ цахим уралдааныг зохион байгуулж, уралдаанд 6-12-р ангийн 94 сурагч, мэргэжлийн 16 багш оролцож, нийт 86 цахим хичээлийн сан бүрдүүлэн иргэдэд цахим орчинд үндэсний бичиг сурах нөхцөлийг бүрдүүлэн, сургалтын цахим хуудсаар дамжуулан хүргэж байна.<br>2. Эх хэлний өдрийг тохиолдуулан “Сайхан бичигтэн” цахим уралдааныг зохион байгуулж, нийт 165 иргэд, албан хаагч, сурагчид үндэсний монгол бичгээр зөв, сайхан бичиж оролцсон.<br>3. Монгол бичгийн цахим хаягаар Монгол бичгийн багш нартай хамтран 7 хоног бүр нэг цагийн сургалтыг зохион байгуулж байна.<br>4. “Үндэсний бичиг үсгийн баяр-2021” арга хэмжээг зохион байгуулж, 46 хүүхэд, залуучууд тус арга хэмжээнд оролцон, Монгол бичгийг нийтэд сурталчилсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо -4<br>Хамрагдсан иргэдийн тоо: 321<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.6.8. Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, хамтран ажиллана. | | | | | | |
| 38 | Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр хамтран ажиллана. | | Гэрээ байгуулан хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тоо 4-өөс доошгүй | 2019 | Гэрээ байгуулан хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тоо -3<br>Зарцуулсан хөрөнгө - 10.0 сая | Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр Орон нутгийн 1 телевиз, радиогийн 1, хэвлэл мэдээлэл, мэдээлэл сурталчилгааны чиглэлээр 3, нийт 5 гэрээг байгуулан ажиллаж, 69 мэдээлэл, 16 шторк, контентийг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэн, Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах арга хэмжээний зардлаас 6.9 сая төгрөг зарцуулсан.<br>Мөн Нийтийн эрүүл мэндийг дэмжих жилийн үйл ажиллагааг сурталчлах, орон нутгийн 7 хоногийн тойм мэдээг бэлтгэн цахимаар хүргэх, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг сурталчлах чиглэлээр шторк, контент бэлтгэх, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулж байгаа арга хэмжээг сурвалжлан хүргэх зэрэг 4 чиглэлийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн хамтран ажилласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Гэрээ байгуулан хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо – 4<br>Зарцуулсан хөрөнгө – 7.2 сая<br>**Хэрэгжилт 100 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.6.9. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 39 | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ хэрэгжүүлнэ. | 20.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь - 100 | 2019 | Залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг 2018-2020 онд хэрэгжүүлэн ажилласан. | Арга хэмжээний төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 76.2 хувьтай хэрэгжүүллээ.<br>Арга хэмжээний хүрээнд:<br>**“Залуучуудын хөгжил оролцоог дэмжих” чиглэлээр:**<br>“Орон нутгийн хөгжил-30” манлайлагч залуусын төлөөллийг оролцуулсан ярилцлага подкаст 1, “Оролцоод манлайлъя” аймгийн залуучуудын цахим чуулган, Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр “Ээждээ би хайртай” цахим дууны уралдаан, “Эрүүл бие-саруул ухаан” гимнастикийн тэмцээн тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 198 залуус танхим, 242 цахимаар оролцож, 8500 гаруй цахим үзэлтийн хандалттай байна. Тус арга хэмжээний үр дүнд залуучуудын хууль, журмын тухай мэдлэг, нийгмийн идэвх оролцоо нэмэгдсэн.<br>**Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, ухааныг иргэдэд сурталчлан түгээх, хүүхдийн дуу хоолойг сонсох чиглэлээр:**<br>Гэр бүлд эерэгээр нөлөөлөх, тэдний хөгжлийг дэмжих, үлгэр дуурайлал бүхий гэр бүлийг алдаршуулах, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Говьсүмбэр телевизтэй хамтран “Сайн ААВ-ХҮҮ, сайхан ЭЭЖ-ОХИН” нэвтрүүлэг, контент бэлтгэн олон нийтэд хүргэсэн. Тус нэвтрүүлэгт орон нутагтаа үлгэр жишээ, урлаг спорт, ажил хөдөлмөрөөр манлайлагч идэвх санаачилгатай гэр бүлийг сонгон оролцуулсан. Тус нэвтрүүлгийг давхардсан тоогоор 2560 иргэдийн хандалт авсан байна.<br>“Хүүхдийн дуу хоолойг сонсох” цахим уулзалтыг зохион байгуулж, нийт 47 төлөөлөл хамрагдаж, өөрсдийн үзэл бодол, тулгамдаж буй асуудлаа илэрхийлэн орон нутгийн удирдлагууд дуу хоолойгоо хүргэсэн.<br>Гэр бүл, боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл цахим орчинд хүүхдийн эрх, хамгаалал хаана, хэрхэн зөрчигдөж байгаа талаар өөрийн үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох, дамжуулах, бодлого хөтөлбөрт тусгах зорилгоор “Бидний дуу хоолой-Бидний ирээдүй” эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулж, 12 сурагч оролцсон. Оролцсон сурагчид өөрийн гэр бүл, амьдарч буй орчны эрүүл ахуйтай холбоотой чухал асуудлуудыг хөндөж, бодлого хөтөлбөрт тусгах санал санаачилгыг илэрхийлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 76.2 хувь<br>**Хэрэгжилт 76.2 хувь** |
| 2.6.10. Хүн амын санг хамгаалах, хүн бүр ураг удмаа мэдэж, өрх бүр угийн бичгээ хөтлөх ажлыг хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 40 | Угийн бичиг хөтлөх арга зүй, ач холбогдлын талаар нөлөөллийн ажил зохион байгуулж, угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлнэ. | | Сургалт нөлөөллийн ажилд хамрагдсан иргэдийн тоо – 1200<br><br>Угийн бичиг хөтөлсөн өрхийн тоо-700 | 2019 | Угийн бичиг хөтлөх арга зүй, ач холбогдлы | Энэ онд “Угийн бичиг хөтлөх арга зүй” анхан шатны сургалтыг цахимаар 26 төрийн байгууллагуудын 601 албан хаагч, 476 иргэнийг хамруулсан.<br>Мөн Сүмбэр сумын 150 малчин, 30 ахмад настан, 23 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ерөнхий боловсролын сургуулийн 355 хүүхдэд сургалт зохион байгуулж, нийт 1635 иргэнд угийн бичиг хөтлөх мэдлэг олгосон бөгөөд 961 өрх угийн бичиг хөтөлсөн байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | н талаар сургалтад 1313 иргэн хамрагдсан. Үүнээс 724 өрх угийн бичиг хөтөлж байна. | **Хүрсэн түвшин:**<br>Хамрагдсан иргэдийн тоо – 1635<br>Угийн бичиг хөтөлсөн өрхийн тоо – 961 /нийт өрхийн 19.3 хувь/<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **Зорилтын дундаж үнэлгээ** | | | | | | **95.1 хувь** |
| **Бодлогын зорилтын дундаж үнэлгээ** | | | | | | **88.0 хувь** |
| **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Санхүү, төсвийн зохицуулалт** | | | | | | |
| **3.1. Санхүү, эдийн засгийн нээлттэй, ил тод байдлыг хангах бодлого хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 3.1.1. Цахим татварын системийг нэвтрүүлэн иргэд татварын үйлчилгээг чирэгдэлгүй авах боломжийг хангах замаар татварын баазыг нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 41 | Цахим татварын системийг нэвтрүүлж, татвар төлөгчдөд татварын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэн, иргэдэд сурталчилна. | 5.0 | Цахим татварын системд ААНБ-ын 90, иргэдийн 50 хувь нь нэвтэрсэн байна. | 2019 | Систем ашиглалтын хувь - 70 | Монголын татварын алба үе шаттайгаар цахим системийг нэвтрүүлэн ажиллаж ирсэн бөгөөд цахим татварын системийн нэвтрэлт 2019 онд 70 хувь, 2020 онд 80 хувь тус тус нэвтрүүлэн, 2021 онд хувь хүн, хуулийн этгээдүүдэд татварын бүх төрлийн үйлчилгээг 100 хувь цахимд нэвтрүүлэн ажиллаж байгаа болно. Тодруулбал: Тайлант хугацаанд өмнөх оны жилийн эцсийн болон 2021 оны 1-4 дүгээр улиралд ирүүлбэл зохих 7872 татварын тайланг 100% цахим татварын системээр хүлээн авч, төсвийн байгууллагуудаас /Сангийн яаманд хүлээгдэж байгаа /бусад татвар төлөгчдийн тайлангаар ногдсон 7,8 тэрбум төгрөгийн албан татварыг нэхэмжлэхэд суурилсан цахим татварын систем болон E-mongolia, Ebarimt, smartcar болон бүх банкны интернет банкаар 100 хувь цахимаар төлүүлэн ажиллав. Түүнчлэн, etax.mta.gov.mn систем болон И монголиа, И баримт, smartcar зэрэг системээс лавлагаа тодорхойлолт авах, татвар төлөгчөөр бүртгүүлэх, татвар төлөгчөөс хасуулах болон бусад 30 гаруй төрлийн үйлчилгээг авах боломжийг хангасан бөгөөд энэ хүрээнд татвар төлөгчөөр бүртгүүлэх 31 хуулийн этгээдийг цахим системээр бүртгэн татварын бааз суурийг өмнөх онтой харьцуулахад 4.6 хувь, 2019 онтой харьцуулахад 10.3 хувиар тус тус нэмэгдүүлэн ажиллав. /Оны эхэнд 623 хуулийн этгээд бүртгэлтэй байсан бол 2021.12.31-ний өдрийн байдлаар 656 болж, 2020 оны жилийн эцсийн тоотой харьцуулахад 4,6 хувиар, 2019 оны мөн үетэй харьцуулахад 591 буюу 10.3 хувиар нэмэгдүүлсэн байна./<br>**Хүрсэн түвшин:**<br>Цахим татварын системд ААНБ 100 хувь,<br>Цахим татварын системд иргэд 100 хувь нэвтэрсэн.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 42 | Татварын бааз суурийг 2020 оны суурь түвшингээс жил бүр 0.5-аас хувиар | | Хуулийн этгээдийн тоо - 656 | 2019 | Хуулийн этгээдийн тоо - 625 | Татвар төлөгчдийн бүртгэлийг сайжруулж, татварын бааз суурийг нэмэгдүүлэх хүрээнд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 623 хуулийн этгээд бүртгэлтэй байсан бол 2021 оны 12 дугаар сарын 31- |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлнэ. | | | | | ний өдрийн байдлаар 656 болж, 2020 оны жилийн эцсийн тоотой харьцуулахад 4.6 хувиар, 2019 оны мөн үетэй харьцуулахад 591 буюу 10.3 хувиар нэмэгдүүлэн ажилласан байна. 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар татвар төлөгчдийн хариуцлагын хэлбэрээр харуулбал: Үүнд: ХК-1, ХХК-340, ББН -5, ЗБН -9, Хоршоо -24, ХЗХоршоо- 1, ОНӨҮГ-6, Салбар-64, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ – 206 байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хуулийн этгээдийн тоо - 656<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 3.1.2. Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай болгон, төсвийн урсгал болон гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | |
| 43 | Төрийн албаны цалингийн нэгдсэн системд төрийн байгууллагуудыг хамруулж, гүйлгээг шуурхай гүйцэтгэнэ. | | Хамрагдах байгууллагын тоо - 54 | 2019 | Хамрагдсан байгууллагын тоо - 49 | Төрийн албаны цалингийн системийг төсвийн байгууллагын орон тоо, цалин хөлсний зардлын хуваарилалтад хяналт тавих, төсвийн үр ашгийг сайжруулах зорилгоор нэвтрүүлэн ажиллаж байна. Төрийн албаны цалингийн нэгдсэн системд нийт хамрагдах 53 байгууллагаас 53 байгууллага одоогоор бүрэн хамруулж, төрийн сангийн төлбөр, тооцооны гүйлгээг хэвийн явагдаж байна.<br>Цагдаагийн хэлтэс, Тагнуулын тасаг, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа 425-р нээлттэй хорих анги гэсэн 4 байгууллагыг нууцын зэрэглэлтэй гэдэг үндэслэлээр тус системд оруулахгүй байхаар Сангийн яамнаас чиглэл өгсний дагуу хамруулаагүй.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хамрагдсан байгууллагын тоо – 53<br>**Хэрэгжилт 80 хувь** |
| 44 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны мэдээ оруулалтад тогтмол хяналт тавина. | | Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо – 81<br><br>Хугацаандаа мэдээ оруулалтын хувь – 90<br><br>Тайлан илгээлтийн хувь - 100 | 2019 | Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо – 81<br><br>Хугацаандаа мэдээ оруулалтын хувь - 87.5<br><br>Тайлан илгээлтийн хувь - 100 | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор аймгийн төсвийн, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, сангууд болон орон нутгаас татаас авч байгаа хувийн цэцэрлэгүүдийн нийт 77 байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд сар бүр тогтмол хяналт шалгалтыг хийж ажиллалаа. Тайлант хугацаанд нийт 25 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг нэг бүрчлэн хянан шалгалаа. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 96.7 хувь байна. Өмнөх оны мөн үеэс 9.2 хувиар өссөн. 2021 оны 4 дүгээр улирлын шилэн дансны тайлан илгээлт 100 хувь. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл дутуу буюу зөрүүтэй илэрхийлсэн давхардсан тоогоор 39 байгууллагуудад хугацаатай албан бичиг хүргүүлэн биелэлтийг нь хангуулан ажиллалаа.<br>Тайлант хугацаанд Баянтал, Шивээговь сумдын Байгаль хамгаалах сан, Мал хамгаалах сангуудын цэсийг хаалгуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо – 77<br>Хугацаандаа мэдээ оруулалтын хувь – 96.7<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 45 | Төсвийн зарцуулалтын үр ашиг, хяналтыг | | Хяналт шалгалтын тоо-21 | 2019 | Хяналт шалгалты | Байгууллагын 2021 онд санхүүгийн хяналт шалгалт-16, дотоод аудит-2 нийт 18 хяналт шалгалт төлөвлөснөөс төлөвлөгөөт 18, төлөвлөгөөт |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулна. | | Зөрчлийн дүн өмнөх онтой харьцуулахад 30 хувиар буурсан байна. | | н тоо-23<br>Илрүүлсэн зөрчлийн дүн-175,787,100 төгрөг | бусаар байгууллагаас ирүүлсэн албан тоот, иргэний өргөдлийг үндэслэн 7 нийт 25 хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар нийт 726,132.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 28,567.1 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 31,739.9 мянган төгрөгийг хувь хүнд нь буцаан олгуулахаар улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоов. Актын барагдуулалт 76.1 хувьтай байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хяналт шалгалтын тоо-25<br>Актын барагдуулалт 76.1 хувь<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 3.1.3. Орон нутагт эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжиж ажиллана. | | | | | | |
| 46 | Орон нутагт эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг газар, дэд бүтэц, зээлийн бодлогоор дэмжинэ. | | Тэргүүлэх салбарын бизнес эрхлэгчдийг газар, дэд бүтэц, зээлийн бодлогоор дэмжинэ. | | | Монгол улсын Засгийн газраас зарласан “Ажлын байрыг дэмжих 2 их наяд төгрөгийн зээл”-ийг орон нутагт арилжааны 3 банкаар дамжуулан олгож байна. 2021 онд дээрх банкуудад 453 үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч 38.5 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт ирүүлснээс 153 аж ахуй нэгж байгууллагад 14.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна.<br>Сум хөгжүүлэх сангаас 3 иргэнд 75.0 сая төгрөгийн зээл олгож, шинээр 6 ажлын байр бий болгосон байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зээлийн дэмжлэг авсан зээлдэгчийн тоо -153<br>Санхүүжилтийн дүн – 14.1 тэрбум төгрөг<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 3.1.4. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх оронч худалдан авалтыг дэмжиж, тендер шалгаруулалтын үйл ажиллагааг бүрэн цахимжуулна. | | | | | | |
| 47 | Орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын ажлуудын бараа материалыг дотоодоос худалдан авах боломж нөхцөлийг бүрдүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана. | | Барилга угсралтын ажлын тендер шалгаруулалтад 100 хувь дотоодын давуу эрх олгох талаар тусгасан байна. | | | 2021 онд 6811.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 58 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зарласан бөгөөд тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх олгох нөхцөлийг 100 хувь тусгасан. Үүнээс 6 компани 109.8 сая төгрөгийн бараа материалын, 7 компани 43 ажиллах хүчний дотоодын давуу эрх тус тус тооцуулж тендерт шалгарсан байна.<br>**Хүрсэн түвшин:** Дотоодын давуу эрх олгох талаар тусгасан худалдан авалтын эзлэх хувь – 100 хувь<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 48 | Тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулна. | | Цахимаар зарласан тендер шалгаруулалтын хувь-100 | 2019 | Цахим тендер шалгаруулалтын хувь-87 | 2021 онд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 6811.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 62 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөснөөс 11 сарын байдлаар 6,588,2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 58 бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулсан.<br>**Хүрсэн түвшин:** Тендер шалгаруулалтыг 100 хувь цахимаар зохион байгуулсан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **Уул уурхай, хүнд үйлдвэр** | | | | | | |
| **3.2. Ил тод хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрийг хөгжүүлэх** | | | | | | |
| 3.2.1. Хүнд үйлдвэрийн бүс байгуулж, боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ. | | | | | | |
| 49 | Хүнд үйлдвэрийн бүс байгуулж, боловсруулах | | Үйлдвэрийн бүсэд хэсэгчилсэн ерөнхий | 2019 | Боловсруулах | Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол шинэчлэл судалгааны ажил хийхээр аймгийн Засаг даргын 2021 оны А/07 дугаар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ. | | төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлнэ. | | үйлдвэрийн тоо-4 | захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, 3 удаа хуралдан Чойр хотын тэг гортигийн хил заагийг тэлэх, хэсэгчилсэн болон дахин төлөвлөлт хийх байршлыг тодорхойлох, орон сууц, үйлчилгээний газруудын цаашдын төлөвлөлтийг тодорхойлох асуудлуудыг хэлэлцэн судалгааг гаргаад байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Судалгааны ажил хийгдсэн.<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| 3.2.2. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, хууль зөрчсөн аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 50 | Орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа хууль зөрчсөн аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах арга хэмжээг авна. | | Хяналт шалгалтын тоо -1<br><br>Хуулийн хэрэгжилтийг хангуулна. | 2019 | Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар хүргүүлсэн саналын тоо-2 | Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/21 дүгээр захирамжаар аймгийн нутаг дэвсгэрт төмөр замыг түшиглэн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд хяналт шалгалт хийх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг 2021 оны 03 дугаар 22-ны өдөр, 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрүүдэд ачилт буулгалтын үйл ажиллагаа явуулж буй 18 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийсэн.<br>Шалгалтаар аж ахуй нэгжүүдэд “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-уудыг зөрчсөн зөрчил илэрсэн тул аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/177 дугаар захирамжаар үйл ажиллагааг нь түр зогсоож, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан 8 аж ахуй нэгж, 1 иргэнийг зөрчлийн тухай хуулийн дагуу торгох шийтгэл оногдуулсан. Зөрчлөө арилгасан аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын гэрээний үндсэн дээр явуулж байна.<br>**Хүрсэн түвшин:** Хяналт шалгалтын тоо-2<br>**Хэрэгжилт 100 хувь** |
